



ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСӨВЛӨЛТ

ОРОН НУТГИЙН ТҮВШИНД НЭВТРҮҮЛЭХ
ЖИШГИЙГ БИЙ БОЛГОХ ХӨТӨЛБӨР
(ДЭД ТӨСӨЛ) ТАЙЛАН

“Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт”-ийг орон нутгийн түвшинд нэвтрүүлэх жишгийг бий болгох хөтөлбөр (дэд төсөл)-ийн тайланг Канад Улсын Засгийн газрын Гадаад хэргийн яамны санхүүжилтээр (2016-2024) хэрэгжиж буй “Монгол Улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах (MERIT)” төслийн хүрээнд нэгтэн боловсруулав.

MERIT нь олборлох салбарын менежментийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилготой засаглал бэхжүүлэх төсөл юм. Засаглалыг бэхжүүлж, хүртээмжтэй эдийн засаг, нийгмийн хөгжлийг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Тайлан боловсруулсан: Ланганы ОТГОНТУЯА
Түвшинбаярын ТУУЛ
Вандангомбын ДАНААСҮРЭН

Хянасан: Раднаабазарын АЛТАНГЭРЭЛ

Төслийн гишүүд: Төмөрсүхийн БАЯРАА
Энхбаатарын АМГАЛАН
Баасанжавын ИЧИНХОРЛОО
Өлзий-Очирын УДВАЛ

■ АГУУЛГА

Нэг. Удиртгал.....	2
Хоёр. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн цахим, танхимын болон зөвлөн туслах цахим үйлчилгээ, бататгах сургалтын явц, үр дүн.....	3
Цахим сургалт.....	3
Танхимын сургалт.....	3
Зөвлөн туслах цахим үйлчилгээ - коучинг.....	4
Багуудын туршлага солилцох буюу төслийн явцын уулзалтууд.....	4
“Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” бататгах сургалт.....	5
Аймгуудын мэдээлэл солилцох нэгдсэн цахим уулзалт.....	6
Оролцогч талуудын үүрэг, оролцоо.....	6
Гурав. ЖМТ-ийн бичил төслүүдийн хэрэгжилтийн нэгтгэсэн үр дүн.....	7
Дөрөв. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн бичил төслүүдийг хэрэгжүүлэхэд тулгарсан хүндрэл, бэрхшээл.....	14
Тав. ЖМТ-ийг хэрэгжүүлснээр хуримтлуулсан туршлага, сургамж.....	15
Бичил төслийг хэрэгжүүлснээр хуримтлуулсан туршлага.....	15
Сургамж.....	16
ЖМТ-ийг нэвтрүүлснээр ажлын гүйцэтгэлд гарц буй ахиц.....	17
Зургаа. Зөвлөмж, цаашид хэрэгжүүлэх чиглэл, үйл ажиллагаа.....	20
Долоо. ЖМТ-ийн бичил төслүүдийг цаашид тогтвортой хэрэгжүүлэхэд учирч болох эрсдэл, сорилт.....	22
Найм. Дүгнэлт.....	23
Ес. Хавсралтууд.....	24



■ НЭГ. УДИРТГАЛ

Жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийн тогтолцоог орон нутаг, байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх аргачлалыг туршиж, цаашид жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн суурь хөрсийг бий болгох, үндэсний хэмжээнд нэвтрүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилгоор MERIT төсөл анх 2020 онд Дорнод аймгийн 80 гаруй төрийн албан хаагчдыг хамруулан Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт туршилтын төслийг хэрэгжүүлсэн билээ.

Төслийн хүрээнд оролцогчид жендэрийн зөрүүтэй байдлыг бууруулах зорилгоор хариу арга хэмжээ авахад чиглэсэн нийт 36 бичил төслийг санаачлан 31 удаа дадлагажуулах (коучинг) буюу зөвлөн туслах цахим үйлчилгээнд хамрагдаж, бичил төслүүдийг сайжруулан нийт 26 төслийг нь амжилттай хэрэгжүүлсэн. Бичил төслүүд амжилттай хэрэгжсэнээр Дорнод аймгийн оролцогчид сурсан мэдлэг, аргачлалаа эзэмшиж, ашиглах чадвартай болсон төдийгүй 2021, 2022 онд бичил төслүүдийнхээ тогтвортой байдлыг ханган орон нутгийн байгууллага, нэгжийн түвшинд төрийн албан хаагчид өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Улмаар Канад Улсын Засгийн газрын санхүүжилттэй MERIT төсөл Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн тэргүүн туршлагыг бусад орон нутгийн захиргааны байгууллагад нэвтрүүлэх дараагийн шатны дэд төслийг 2022 оны 6-р сараас 2022 оны 12-р сарын хооронд Дундговь, Төв, Сүхбаатар аймгийн төрийн албан хаагчдыг хамруулан Удирдлагын академи хамтран Жендэрийн үндэсний хорооны дэмжлэгтэйгээр амжилттай хэрэгжүүллээ.

Уг дэд төслийн бэлтгэл ажлын хүрээнд “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” цахим сургалтын 1-р хэсэг болох “Нэгжийн түвшинд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэвтрүүлэх нь” сэдэвт 10 модуль багцыг MERIT төслийн Техникийн зөвлөх Мишэл Филион, Үндэсний зөвлөх Ланганы Отгонтуяа нартай хамтран MERIT төслийн баг боловсруулсан юм.

Ийнхүү “Нэгжийн түвшинд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэвтрүүлэх нь” сэдэвт цахим сургалтын нээлтийг 2022 оны 6 дугаар сарын 3-ны өдөр хийж, Удирдлагын академийн 11 багш, Жендэрийн үндэсний хорооны 8 төрийн албан хаагч, жендэрийн шинжээчид болон MERIT төслийн хамтрагч 3 аймгийн төрийн албан хаагчдыг хамруулав.

Цахим сургалтыг амжилттай судалсан Удирдлагын академийн 8 багш, Жендэрийн үндэсний хорооны 6 төрийн албан хаагчдад 2022 оны 6-р сарын 20-ны өдрөөс эхлэн танхимын 1 өдрийн, харин аймаг, сумын 95 төрийн албан хаагчдад 3 удаа тус бүр танхимын 1.5 өдрийн сургалтыг зохион байгуулж, цахим сургалтаар олж авсан мэдлэг, ур чадварыг бататгасны зэрэгцээ жендэрийн зөрүүтэй байдлыг арилгахад чиглэсэн 35 бичил төслийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн сургалтын үе шатууд:

- ЖМТ цахим сургалтын багц 1 (Модуль 1-10)
- ЖМТ танхимын 1.5 өдрийн сургалт
- Ганцаарчилсан болон бичил төслийн багуудад өгөх зөвлөн туслах цахим үйлчилгээ (коучинг)
- Аймгуудын бичил төслийн багуудын туршлага солилцох болон төслийн явцыг хэлэлцэх уулзалтууд
- ЖМТ бататгах сургалт 1 өдөр
- Аймгуудын мэдээлэл солилцох нэгдсэн цахим уулзалт

■ ХОЁР. ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСӨВЛӨЛТИЙН ЦАХИМ, ТАНХИМЫН БОЛОН ЗӨВЛӨН ТУСЛАХ ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ, БАТАТГАХ СУРГАЛТЫН ЯВЦ, ҮР ДҮН

Цахим сургалт

“Нэгжийн түвшинд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэвтрүүлэх нь” цахим сургалтад 2022 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар хамрагдсан төрийн албан хаагчдын мэдээллийг дараах хүснэгтэд нэгтгэн харуулав.

Хүснэгт 1. “Нэгжийн түвшинд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэвтрүүлэх нь” цахим сургалтад хамрагдсан төрийн албан хаагчид, аймгаар

	Бүртгүүлсэн			Сургалтаа дуусгасан		
	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт
Дорнод	41	10	51	27	4	31
Дундговь	277	61	338	162	42	204
Сүхбаатар	384	166	550	261	101	362
Төв	267	83	350	202	53	255
Нийт	969	320	1289	652	200	852

“Нэгжийн түвшинд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэвтрүүлэх нь” цахим сургалтад Дорнод, Дундговь, Төв, Сүхбаатар аймгийн нийт 1,289 төрийн албан хаагчид нэвтэрч бүртгүүлсний 75.2 хувийг эмэгтэй, харин 24.8 хувийг эрэгтэй төрийн албан хаагчид эзэлж байв. Нийт бүртгүүлсэн албан хаагчдын 66.1 хувь нь сургалтаа бүрэн дуусгасан бөгөөд тэдний 76.5 хувь нь эмэгтэй, 23.5 хувь нь эрэгтэй ТАХ байна.

Сургалтаа амжилттай дүүргэсэн хүмүүсийн 3.6 хувийг Дорнод, 23.9 хувийг Дундговь, 42.5 хувийг Сүхбаатар, 29.9 хувийг Төв аймгийн төрийн албан хаагчид эзэлж байв.

Танхимын сургалт

MERIT төсөл, ЖҮХ, Удирдлагын академи хамтран 2022 оны 6-р сарын 20-ны өдөр Жендэрийн шинжээчид, ЖҮХ-ны ажилтнууд болон Удирдлагын академийн багш нарт зориулсан сургалтыг зохион байгуулж, MERIT төслийн олон улсын зөвлөх Мишэл Филион чиглүүлж ажилласан. Сургалтын хөтөлбөрийн дагуу оролцогчид ЖМТ-ийн цахим болон танхимын сургалтын арга зүйг оновчтой болгох зорилгоор бүлгээр ажиллан үг хэллэг, сургалтын бүтэц, хэлбэр, дасгал ажлууд гэх зэргээр анхаарах асуудлыг тодорхойлж, сайжруулах саналыг нэгтгэн гаргаж, хэлэлцүүлэг өрнүүлсэн. Тус саналд тулгуурлан ЖМТ цахим болон танхимын сургалтын модульд зарим өөрчлөлтийг оруулсан.

Танхимын сургалтын явцад Олон улсын зөвлөх Мишэл Филион цалингийн хуваарилалт болон үр шим хүртэгчдийн зөрүүтэй байдлыг тодорхойлоход үүсдэг бэрхшээлүүд, жендэрийн зөрүүтэй байдал үүсч буй шалтгааныг тодорхойлох арга зүй, үр дүнгийн гинжин хэлхээ, төслийн дотоод логик зэрэг сэдвээр оролцогчдод танилцуулга хийж, цахим сургалтаар олж авсан мэдлэг, чадвараа бататгахад нь дэмжлэг үзүүлж хамтран суралцах боломжийг олгов.

Энэ сургалтад Жендэрийн шинжээч, Жендэрийн үндэсний хорооны 5 албан хаагч, Удирдлагын академийн 9 багш, ажилтан хамрагдсаны 78.6 хувь нь эмэгтэй, 21.4 хувь нь эрэгтэй оролцогч байлаа.



Орон нутгийн төрийн албан хаагчдад зориулсан сургалтыг 2022 оны 6-р сарын 21-22-ны өдрүүдэд Дундговь аймгийн 31 оролцогч (20 эмэгтэй, 11 эрэгтэй), 2022 оны 6-р сарын 23-24-ний өдрүүдэд Сүхбаатар аймгийн 32 оролцогч (20 эмэгтэй, 12 эрэгтэй), 2022 оны 6-р сарын 27-28-ны өдрүүдэд Төв аймгийн 32 оролцогч (16 эмэгтэй, 16 эрэгтэй)-ийг хамруулан явуулж, MERIT төслийн Олон улсын зөвлөх Мишэл Филион, Үндэсний зөвлөх Л.Отгонтуяа, В.Данаасүрэн нар сургагч багшаар MERIT төслийн багтай хамтран ажиллав.

Эдгээр сургалтын хүрээнд оролцогчид хөтөлбөр, арга хэмжээгээ сонгож, сонгосон хөтөлбөртөө жендэрийн дүн шинжилгээ хийж эмэгтэй, эрэгтэй хүмүүст хүрч буй төрийн үйлчилгээ болон үр шим хүртэгчдийн жендэрийн зөрүүтэй байдлыг үүсгэж буй шалтгаан, бичил төслийн хүрээнд хэрэгжүүлэх тусгай арга хэмжээг тодорхойлоход нь олон улсын болон дотоодын сургагч багш нар дэмжлэг үзүүлэн ажиллав. Энэ нь MERIT төслийн үндэсний зөвлөхүүд олон улсын зөвлөлтэй хамтран ажиллах явцдаа эзэмшсэн мэдлэг, чадвараа бататгаж, өөрийн болгох, сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдад жендэрийн мэдрэмжээ дээшлүүлэхэд нь MERIT төслийн багийнхны хамт дэмжлэг үзүүлэх, орон нутгийн бодлого, шийдвэрт жендэрийг тусгах талаар хамтран шийдэл гаргах зэрэгт чухал ач холбогдолтой байлаа.

Нийт 3 сургалтын үр дүнг нэгтгэвэл Дундговь аймгаас 31, Сүхбаатар, Төв аймгаас тус бүр 32, нийт 95 оролцогч буюу төрийн албан хаагчийг хамруулан 2-5 хүнтэй нийт 35 багт хуваан ажиллуулж, бичил төслүүдийг боловсруулан танилцуулж, цаашид хэрэгжүүлж ажиллахаар болсон юм. Сургалтын эхэнд суралцагчид жендэрийн талаар ойлголт, мэдлэг багатай байсан бол 1.5 өдрийн сургалтын үр дүнд тэдний мэдлэг, чадвар харьцангуй сайжирч, боловсруулсан бичил төслүүдийн чанар дээшилж байв.

ЖМТ-ийн цахим сургалтаа амжилттай дүүргэж, танхимын 1.5 өдрийн сургалтад хамрагдсан нийт оролцогчдын 56 нь буюу 58.9% нь эмэгтэй, 39 буюу 41.1% эрэгтэй төрийн албан хаагч байна.

Зөвлөн туслах цахим үйлчилгээ - коучинг

ЖМТ-ийн танхимын сургалтад хамрагдах явцад боловсруулсан жендэрийн зөрүүтэй байдлыг бууруулахад чиглэсэн бичил төслийг хэрэгжүүлж буй 35 баг тус бүрт зөвлөн туслах цахим үйлчилгээг үндэсний зөвлөх Л.Отгонтуяа, В.Данаасүрэн, төслийн ажилтан нар урьдчилан ярилцаж тогтсон цагийн хуваарь, коучинг хийх зааварчилгаа, удирдамжийн дагуу хүргэж ажиллалаа. Бичил төслийг хэрэгжүүлэх явцад хүндрэл учирсан зарим багт дахин коучинг хийснийг тэмдэглэх нь зүйтэй.

Бичил төслийн багуудыг чадавхжуулах коучинг буюу чиглүүлэх зөвлөн туслах цахим үйлчилгээг үзүүлэхдээ бичил төслийн хэрэгжилтийн явцтай танилцаж, төслөө хэрэгжүүлэхэд нь шаардагдаж буй туслалцаа, дэмжлэгийн талаар асууж ярилцан санал солилцсон болно. Үүний зэрэгцээ бичил төслийн нэр, хамрах хүрээ, зорилго, зорилт, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, шаардагдах цаг хугацаа, төсөв, төслийн үр дүнг нарийвчлан тодорхойлоход анхаарч ажиллав. Түүнчлэн бичил төслийн багууд төслөө амжилттай хэрэгжүүлэхийн тулд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллахыг зөвлөсөн нь тэднийг хүрэхээр зорьсон үр дүндээ хүрч, жендэрийн зөрүүтэй байдлыг арилгахад чиглэсэн тусгай арга хэмжээгээ тогтвортой хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн.

Багуудын туршлага солилцох буюу төслийн явцын уулзалтууд

Дундговь, Сүхбаатар, Төв аймгийн бичил төслийн багуудын хооронд туршлага солилцох (төслийн явцын) уулзалтыг аймаг тус бүрийн багийн ахлагч, MERIT төслийн ажилтнууд үндэсний зөвлөхүүдтэй хамтран зохион байгууллаа. Энэ



уулзалтаар тухайн аймгийн оролцогчид бусад багийнхаа хэрэгжүүлж буй бичил төслийн явц, үйл ажиллагаа, завсрын үр дүнтэй нь харилцан танилцаж, туршлагаа хуваалцан бие биеэсээ суралцах нөхцөл бүрдсэн нь бичил төслүүдийг амжилттай хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой болсон юм.

“Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” бататгах сургалт

“Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” цахим болон танхимын сургалтаар олж авсан мэдлэг, чадвараа бататгах нэг өдрийн сургалтыг хамтрагч 3 аймаг тус бүрд оролцогчдыг танхимд цуглуулан 2022 оны 11 дүгээр сард зохион байгуулав.

Тус сургалтаар жендэрийн зөрүүтэй байдлыг бууруулахад чиглэсэн бичил төслийг боловсруулж, хэрэгжүүлсэн багууд төслийнхөө танилцуулгыг хийхдээ:

- Бичил төслийн үндэслэл, зорилго, зорилт
- Бичил төслийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
- Бичил төслийн явц, үр дүн
- Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, эргэлзээ
- Бичил төслийг хэрэгжүүлснээр хуримтлуулсан туршлага, сургамжийг баримт, нотолгоотойгоор танилцуулан чиглүүлэгчид болон оролцогчдын тавьсан асуултад хариулж, бүтээлч хэлэлцүүлэг өрнүүлсэн.

Багуудын танилцуулгад тулгуурлан оролцогчид 4-5 бүлэгт хуваагдан бичил төсөл хэрэгжүүлсэн туршлагаа солилцож, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг хэрэгжүүлэхэд тулгарсан бэрхшээл, эргэлзээ, сургамжийг нэгтгэн хэлэлцэж, сайн туршлагаа тодорхойлноос гадна өмнөх туршлагадаа тулгуурлан цаашид жендэрийн эрх тэгш байдлыг хангахын тулд хэрхэн хамтран ажиллах талаар саналаа гаргасан юм.

Бататгах сургалтын хүрээнд “Макро түвшний хүчин зүйлсийг ойлгохын тулд том зургаар харах нь” сэдвээр MERIT төслийн үндэсний зөвлөх Л.Отгонтуяа товч лекц уншиж, жендэрийн практик хэрэгцээ ба стратегийн сонирхлын онцлог, макро түвшний бодлого ба макро түвшин дэх жендэрийн зөрүүтэй байдал, нийгэмд чиглэсэн төсвийн зарлагын сонголт, төсвийн орлого бүрдүүлэлт, татвар ногдуулалтын үр нөлөө, жендэрийн нөлөөлөл, жендэрийн нарийвчилсан шинжилгээ, шийдвэр гаргалт, нийгэмшүүлэх болон соёлын бодлогод жендэрийн талаас анхаарах асуудлуудыг танилцуулав.

Мөн оролцогчид нийгэм дэх макро түвшний жендэрийн зөрүүтэй байдалд дүн шинжилгээ хийж, орон нутаг болон байгууллагаас үйлчилгээ хүртэгч нийгмийн тодорхой бүлгүүдийг төлөөлөх зохиомол дүрийн өгөгдөлд тулгуурласан “Персона аргачлал”-ыг ашиглан дасгал ажиллав. Энэхүү аргачлалын дагуу багууд өгөгдсөн дүр бүрийн оронд өөрийгөө тавьж, тухайн хүний хэрэгцээ, зорилго юу байж болох, уг persona төр, орон нутаг, байгууллагаас юу хүсч болох, төрийн албан хаагчийн хувьд тухайн хүмүүст хэрхэн тусалж чадах, түүний амьдралыг сайжруулахын тулд хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр, санаачилгын талаар саналаа боловсруулж, багийн ажлыг танилцуулж, нийтээр хэлэлцлээ.

Ингэснээр оролцогчид орон нутагт төдийгүй нийгэм дэх жендэрийн зөрүүтэй байдлыг бууруулахад чиглэсэн бодлого, хөтөлбөр боловсруулж, санал гарган хэрэгжүүлэхдээ үр шим хүртэгчдийн жендэрийн ялгаатай хэрэгцээг харгалзан үзэж, үр дүн, үр нөлөөг нь жендэрийн талаас үнэлэх арга зүйд суралцсан юм.

Сургалтын төгсгөлд “Орон нутаг, байгууллагын түвшинд жендэрийн зөрүүтэй байдлыг бууруулах зорилгоор ЖМТ-ийг тогтвортой хэрэгжүүлэх арга зам”-ыг тодорхойлох багийн ажлыг гүйцэтгэж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг аймаг тус бүр 4 үндсэн чиглэлээр нэгтгэн гаргав.



Аймгуудын мэдээлэл солилцох нэгдсэн цахим уулзалт

Дундговь, Сүхбаатар, Төв аймгийн ЗДТГ, MERIT төслийн хамтарсан хөтөлбөрийн хүрээнд “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” сэдвээр аймгуудын мэдээлэл солилцох нэгдсэн уулзалтыг 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр цахимаар зохион байгуулав.

Аймгуудын мэдээлэл солилцох нэгдсэн цахим уулзалтад “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” анхан шатны сургалтад хамрагдаж, бичил төсөл боловсруулан хэрэгжүүлсэн Дундговь, Сүхбаатар, Төв аймгийн төрийн албан хаагчид, Сангийн яам, Жендэрийн үндэсний хороо, Удирдлагын академи, MERIT төслийн төлөөлөл хамрагдав. Жендэрийн зөрүүтэй байдлыг бууруулах зорилгоор аймаг бүрд хэрэгжүүлсэн бичил төслүүдийн нэгтгэсэн танилцуулгыг Төв аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн дарга Д.Мөнхцэцэг, Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн дарга Р.Алтаннар, Дундговь аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн мэргэжилтэн Б.Дэлгэрмаа нар хийж, бичил төслүүдийн үр дүн, тулгарсан бэрхшээл, асуудал, хуримтлуулсан туршлага, сургамжийн талаараа дэлгэрэнгүй танилцуулсан.

Үүний зэрэгцээ Дундговь, Сүхбаатар, Төв аймгуудад хэрэгжүүлсэн жендэрийн зөрүүтэй байдлыг бууруулахад чиглэсэн бичил төслийн нэгдсэн үр дүн, сорилт, сургамжийг MERIT төслийн ажилтан, аймгуудын бататгах сургалтын явцад оролцогчдын тодорхойлсон “Орон нутаг, байгууллагын түвшинд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг тогтвортой хэрэгжүүлэх арга зам”-ын талаарх саналын нэгтгэлийг MERIT төслийн үндэсний зөвлөх Л.Отгонтуяа нар танилцуулсан болно.

Ийнхүү аймаг тус бүрийн оролцогчид багаар ажиллах замаар “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг тогтвортой хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулан багийн ажлын үр дүнг илтгэж, цахим уулзалтад оролцогчид саналаа нэгтгэн хэлэлцсэн. Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөө нь “Жендэрийн эрх тэгш байдлыг 2022-2031 онд хангах салбар дундын стратеги төлөвлөгөө”-нд тусгагдан батлагдсанаар аймаг, сум, байгууллагын түвшинд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг тогтвортой хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ гэж цахим уулзалтад оролцогчид санал нэгтэй дүгнэсэн юм.

Оролцогч талуудын үүрэг, оролцоо

MERIT төслийн хүрээнд Дундговь, Сүхбаатар, Төв аймгийн ЗДТГ, Удирдлагын академи, ЖҮХ хамтран “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талууд дараах үүргийг гүйцэтгэн идэвх, санаачилга гарган оролцлоо. Тухайлбал:

- Удирдлагын академи Монгол улсын болон орон нутаг, байгууллагын онцлог, нөхцөл байдалд нийцүүлэн зөвлөн чиглүүлэх ажлыг голлон гүйцэтгэсэн.
- Аймаг, сумдын ЗДТГ-ын зүгээс бичил төсөл хэрэгжүүлж буй баг, төрийн албан хаагчдыг удирдлагын манлайллаар ханган дэмжлэг үзүүлж ажилласан.
- Жендэрийн үндэсний хороо үндэсний чадавхыг бэхжүүлэх бодлого, стратегийг тодорхойлж, аймаг, сум, байгууллагын түвшинд хэрэгжүүлэх үйл явцад дэмжлэг үзүүлж, үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна.



■ ГУРАВ. ЖМТ-ИЙН БИЧИЛ ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮН

Жишиг төслийн хүрээнд хийгдсэн танхимын болон цахим сургалтын явцад оролцогчид байгууллага, үйл ажиллагаандаа жендэрийн дүн шинжилгээ хийж, жендэрийн зөрүүтэй байдлыг тодорхойлон зөрүүтэй байдлыг багасгах бичил төслүүдийг боловсруулан амжилттай хэрэгжүүлэхэд нь төрийн албан хаагчдыг чиглүүлэн зөвлөн тусалж ажилласны үр дүнд нийт боловсруулсан 35 бичил төслийн 94.3% нь амжилттай хэрэгжсэн үр дүнтэй байна.

Аймгуудад хэрэгжүүлсэн жендэрийн зөрүүтэй байдлыг бууруулахад чиглэсэн бичил төслүүдийн жагсаалт болон төслийн багт ажилласан төрийн албан хаагчдын ажил, албан тушаал, хүйсийн мэдээллийг хавсаргав (Хавсралт 2, 3).

Харин 3 аймагт хэрэгжүүлсэн жендэрийн зөрүүтэй байдлыг бууруулахад чиглэсэн бичил төслүүдийн тоо, багийн гишүүдийн нэгтгэсэн мэдээллийг дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 2. Аймгуудад хэрэгжүүлсэн бичил төслүүд болон багийн гишүүдийн мэдээллийн нэгтгэл

№	Аймаг	Боловсруулсан төслийн тоо	Багийн гишүүд			Хэрэгжүүлсэн төслийн тоо	Багийн гишүүд		
			Нийт	Эмэгтэй	Эрэгтэй		Нийт	Эмэгтэй	Эрэгтэй
1.	Дундговь	10	31	20	11	9	29	19	10
2.	Сүхбаатар	12	32	20	12	11	29	18	11
3.	Төв	13	32	16	16	12	29	15	14
	Нийт	35	95	56	39	32	87	52	35

Танхимын сургалтад оролцогчид нийт 35 бичил төслийг боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн боловч зарим төрийн албан хаагчдын ажил, албан тушаал өөрчлөгдсөн тул аймаг тус бүрээс нэг бичил төслийг хэрэгжүүлэх боломжгүй болсон ч эдгээр аймгийн 87 оролцогч нийт 32 бичил төслийг амжилттай хэрэгжүүлж чадсан юм.

Жендэрийн зөрүүтэй байдлыг бууруулахад чиглэсэн бичил төслүүдийг хэрэгжүүлсэн төрийн албан хаагчдын мэдээллийг аймаг, сум, байгууллагаар нь бүлэглэхэд дараах байдалтай байна.


Хүснэгт 3. Жендэрийн зөрүүтэй байдлыг бууруулахад чиглэсэн бичил төслүүдийг хэрэгжүүлсэн төрийн албан хаагчид, байгууллагаар

№	Аймаг	Аймгийн ИТХ	Аймгийн ЗДТГ	Аймгийн агентлаг	Сумын ИТХ	Сумын ЗД, ЗДО	Сумын ЗДТГ	МСҮТ, ЕБС, СӨББ	Нийт
1.	Дундговь	-	7	10	1	4	5	2	29
2.	Сүхбаатар	1	10	11	2	1	4	-	29
3.	Төв	-	8	16	-	1	1	3	29
	ДҮН	1	25	37	3	6	10	5	87

Бичил төсөл хэрэгжүүлсэн багийн гишүүдийн 29 хувь нь аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, 43 хувь нь аймгийн агентлагуудын дарга, мэргэжилтнүүд, 11 хувь нь сумын ЗДТГ-ын дарга, мэргэжилтнүүд байна.



Зураг 1. Бичил төсөл хэрэгжүүлсэн төрийн албан хаагчдын бүтэц, байгууллагаар



Харин үлдэх 17 хувийг аймаг, сумын ИТХ-ын Төлөөлөгчид, ИТХ-ын нарийн бичгийн дарга нар, сумдын Засаг дарга, Засаг даргын орлогч нар эзэлж байгааг дээрх зургаас харж болно. Энэ нь бичил төслийг хэрэгжүүлснээр аймаг, сумын төрийн жинхэнэ албан хаагчдын жендэрийн талаарх мэдлэг, ойлголт, хандлага өөрчлөгдөх боломж бүрдсэнийг харуулж байгаа юм.

Хүснэгт 4. Дундговь аймагт хэрэгжсэн төслүүд, салбараар

№	Салбар, чиглэл	Төслийн нэр
1.	Байгаль орчныг хамгаалах	Байгаль хамгаалагч эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх
2.	Боловсролын салбар,	Тэгш оролцоотой гэр бүл - Цэцэрлэг
3.	боловсролыг дэмжих	Уншигч эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх
4.	Төрийн захиргаа, шийдвэр гаргах	Төрийн албаны удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх
5.		Гурвансайхан сумын ИТХ, ЗДТГ дахь зөвлөл, хороод, ажлын хэсэг дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
6.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Малжуулах хөтөлбөрт эмэгтэй малчдын оролцоог нэмэгдүүлэх
7.		Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар орлогыг нь нэмэгдүүлэх
8.	Иргэдийн жендэрийн ойлголт, хандлагад нөлөөлөх	Малчин өрхийн жендерийн хэвшмэл байдлыг өөрчлөх
9.		Мянгат малчдын зөвлөгөөнд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх

Хүснэгт 5. Сүхбаатар аймагт хэрэгжсэн төслүүд, салбараар

№	Салбар, чиглэл	Төслийн нэр
1.	Байгаль орчныг хамгаалах	Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт эмэгтэй байгаль хамгаалагчдын тоог нэмэгдүүлэх нь
2.	Боловсролын салбар,	Аймгийн ЗДТГ-ын эмэгтэй албан хаагчдын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх нь
3.	боловсролыг дэмжих	Мэргэжлийн боловсрол эзэмшиж буй охидын тоог нэмэгдүүлэх нь
4.	Төрийн захиргаа, шийдвэр гаргалт, орон нутгийн бодлого боловсруулах	Байгууллагын дотоод журмыг жендэрийн мэдрэмжтэй болгох нь
5.		Нийгмийн даатгалын хэлтсийн эмэгтэй ТАХ-ийн нийгмийн баталгааг нэмэгдүүлэх нь
6.		Жендэрийн мэдрэмжтэй спортыг дэмжих орон нутгийн бодлого боловсруулах нь
7.		Бүсгүйн гараа
8.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Эмэгтэйчүүдийн ур чадварыг дээшлүүлж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх нь
9.		Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь
10.		Хоршооны зээлд эмэгтэйчүүдийн оролцоог хангах нь
11.	Соёлын салбарт чиглэсэн	Соёл ба жендэр

Хүснэгт 6. Төв аймагт хэрэгжсэн төслүүд, салбараар

№	Салбар, чиглэл	Төслийн нэр
1.	Байгаль орчныг хамгаалах	Ойн нөхөрлөлийн гишүүдийн тэгш оролцоог хангах
2.	Боловсролын салбар, боловсролыг дэмжих	Эрдэнэ МСҮТ-ийн малчны ангид суралцах эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх нь
3.		Оюунлаг эмэгтэйчүүд
4.	Төрийн захиргаа, шийдвэр гаргалт, орон нутгийн бодлого боловсруулах	Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд иргэдийн саналыг тусгахад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
5.		Албан томилолтын зардалд жендэрт суурилсан аудит хийх
6.		Хүүхдэд ээлтэй орчин
7.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	ХЭДС-аас олгож байгаа аж ахуй эрхлэгчдийг дэмжих санхүүгийн дэмжлэгийг жендэрийн мэдрэмжтэй хуваарилах
8.	Соёлын салбарт чиглэсэн	Морин хуур хөгжмөөр хичээллэх охидын тоог нэмэгдүүлэх
9.		Соёлын биет бус өвийн эмэгтэй өвлөн уламжлагчийг илрүүлж, нэмэгдүүлэх
10.	Иргэдийн жендэрийн ойлголт, хандлагад нөлөөлөх	Жирэмсэн эхчүүдийн ар гэрт, жирэмсний хяналтын чанарыг сайжруулах гэр үнэлгээг нэвтрүүлэх нь
11.		Илүүдэл жингүй Угтаалын эмэгтэйчүүд
12.		Гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх зан үйлд нөлөөлөх



Хүснэгт 7. Аймгуудад хэрэгжүүлсэн бичил төслүүдийн нэгтгэл, салбараар

№	Салбар, чиглэл	Дундговь	Сүхбаатар	Төв	Нийт
1.	Байгаль орчныг хамгаалах	1	1	1	3
2.	Боловсролын салбар, боловсролыг дэмжих	2	2	2	6
3.	Төрийн захиргаа, шийдвэр гаргалт, орон нутгийн бодлого боловсруулах	2	3	3	8
4.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	2	4	1	7
5.	Иргэдийн жендэрийн ойлголт, хандлагад нөлөөлөх	2		3	5
6.	Соёлын салбарт чиглэсэн		1	2	3
Дүн		9	11	12	32

Аймгуудад хэрэгжсэн нийт 32 төслийн 3 нь байгаль орчныг хамгаалах, 6 нь боловсролын салбар, боловсролыг дэмжих, 8 нь төрийн захиргаа, шийдвэр гаргалт, орон нутгийн бодлого боловсруулах, 7 нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, 6 нь иргэдийн жендэрийн ойлголт, хандлагад нөлөөлөх, 3 нь соёлын салбарт чиглэсэн байна.

Хүснэгт 8. Бичил төслүүдийн хэрэгжилт, 2023 оны 1 дүгээр сарын байдлаар

№	Хэрэгжилтийн түвшин	Дундговь	Сүхбаатар	Төв	Нийт
1.	Бүрэн хэрэгжсэн (100 хувь)	9	10	8	27
2.	Бүрэн хэрэгжихэд ойрхон байгаа (80-95 хувь)	-	-	4	4
3.	Хэрэгжих шатандаа байгаа (70 хувь)	-	1	-	1
	Хэрэгжилтийн дундаж хувь	100%	97.3%	95.3%	97.5%

Бичил төслүүдийн хэрэгжилтийг 2023 оны 1-р сарын байдлаар нэгтгэн авч үзвэл бүрэн хэрэгжиж дууссан 27 төсөл, 80-95 хувийн хэрэгжилттэй байгаа 4 төсөл, 70 хувьтай буюу хэрэгжих шатандаа байгаа 1 төсөл байна. Эдгээр бичил төслийн хэрэгжилтийн дундаж хувь 97.5 хувь байгаа нь эдгээр төсөл амжилттай, үр дүнтэй хэрэгжсэнийг илтгэнэ.

Дундговь аймагт хэрэгжсэн 9 төслийн 6 нь буюу 66.7%, Сүхбаатар аймгийн 11 төслийн 9 нь буюу 81.8%, Төв аймгийн 12 төслийн 10 нь буюу 83.3% нь “тэг” төсөвтэйгөөр, өөрөөр хэлбэл, ямар нэгэн нэмэлт санхүүжилтгүйгээр хэрэгжсэн байна (Хүснэгт 9).

Дундговь аймаг	Сүхбаатар аймаг	Төв аймаг
1. Байгаль хамгаалагч эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх 2. Тэгш оролцоотой гэр бүл - Цэцэрлэг 3. Төрийн албаны удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх 4. Гурвансайхан сумын ИТХ, ЗДТГ дахь зөвлөл, хороод, ажлын хэсэг дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх 5. Малжуулах хөтөлбөрт эмэгтэй малчдын оролцоог нэмэгдүүлэх 6. Уншигч эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх	1. Аймгийн ЗДТГ-ын эмэгтэй албан хаагчдын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх нь 2. Мэргэжлийн боловсрол эзэмшиж буй охидын тоог нэмэгдүүлэх нь 3. Байгууллагын дотоод журмыг жендэрийн мэдрэмжтэй болгох нь 4. Нийгмийн даатгалын хэлтсийн эмэгтэй ТАХ-ийн нийгмийн баталгааг нэмэгдүүлэх нь 5. Жендэрийн мэдрэмжтэй спортыг дэмжих орон нутгийн бодлого боловсруулах нь 6. Эмэгтэйчүүдийн ур чадварыг дээшлүүлж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх нь 7. Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь 8. Хоршооны зээлд эмэгтэйчүүдийн оролцоог хангах нь 9. Соёл ба жендэр	1. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд иргэдийн саналыг тусгахад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь 2. Албан томилолтын зардалд жендэрт суурилсан аудит хийх 3. ХЭДС-аас олгож байгаа аж ахуй эрхлэгчдийг дэмжих санхүүгийн дэмжлэгийг жендэрийн мэдрэмжтэй хуваарилах 4. Ойн нөхөрлөлийн гишүүдийн тэгш оролцоог хангах 5. Эрдэнэ МСҮТ-ийн малчны ангид суралцах эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх нь 6. Оюунлаг эмэгтэйчүүд 7. Соёлын биет бус өвийн эмэгтэй өвлөн уламжлагчийг илрүүлж, нэмэгдүүлэх 8. Жирэмсэн эхчүүдийн ар гэрт, жирэмсний хяналтын чанарыг сайжруулах гэр үнэлгээг нэвтрүүлэх нь 9. Гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх зан үйлд нөлөөлөх 10. Морин хуур хөгжмөөр хичээллэх охидын тоог нэмэгдүүлэх
6/9 нь 66.7%	9/11 нь 81.8%	10/12 нь 83.3%

Тэг төсөвтэй хэрэгжсэн төслүүд нь нэгжийн түвшинд жендэрийн зөрүүтэй байдлыг арилгахад чиглэсэн арга хэмжээг байгууллага, орон нутаг өөрийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд холбогдох бодлогын баримт бичиг, дотоод журам, удирдамж, заавартаа тодорхой тусган тогтвортой хэрэгжүүлэх бүрэн боломжтойг харуулсан болно. Тухайлбал, Дундговь аймгийн төрийн албан хаагчид ЖМТ-ийн бичил төслүүдийг амжилттай хэрэгжүүлсэн нь “тэг” төсөвтэйгөөр ажлыг хийж болдог гэдгийг харуулж, бусдад түгээх сайн туршлага болсон гэж дүгнэсэн юм.

Энэ нь нэгж, байгууллага, орон нутгийн түвшинд үндсэн чиг үүргийнхээ хүрээнд үзүүлж буй үйлчилгээ, үйл ажиллагааг жендэрийн талаас нь харж бодлогын баримт бичгүүдэд тодорхой заалт тусгахын зэрэгцээ төлөвлөлт, төсөвлөлт, шийдвэр гаргалт, хэрэгжүүлэлт, хяналт шинжилгээ, тайлагнал, нөлөөллийн үнэлгээг хийхдээ жендэрийн мэдрэмжтэйгээр хандаж, ямар нэгэн нэмэлт төсөв,



санхүүжилт шаардахгүйгээр үйлчилгээний үр ашиг, үр шимийг нь сайжруулан ажиллаж болохыг төрийн албан хаагчид ойлгосныг илтгэж байна.

Хүснэгт 10. Амжилттай хэрэгжсэн бичил төслүүд

Дундговь аймаг	Сүхбаатар аймаг	Төв аймаг
1. Гурвансайхан сумын ИТХ, ЗДТГ дахь зөвлөл, хороод, ажлын хэсэг дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх	1. Бүсгүйн гараа	1. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд иргэдийн саналыг тусгахад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь
2. Төрийн албаны удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх	2. Аймгийн ЗДТГ-ын эмэгтэй албан хаагчдын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх нь	2. Албан томилолтын зардалд жендэрт суурилсан аудит хийх
3. Тэгш оролцоотой гэр бүл - Цэцэрлэг	3. Байгаль орчны салбарт ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх замаар эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь	3. Морин хуур хөгжмөөр хичээллэх охидын тоог нэмэгдүүлэх
4. Байгаль хамгаалагч эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх	4. Байгууллагын дотоод журам, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг жендэрийн мэдрэмжтэй болгох нь	4. Эрдэнэ МСҮТ-ийн малчны ангид суралцах эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх нь
5. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар орлогыг нь нэмэгдүүлэх		5. Илүүдэл жингүй Угтаалын эмэгтэйчүүд
		6. Хүүхдэд ээлтэй орчин

Дундговь, Сүхбаатар, Төв аймагт ЖМТ-ийн бичил төсөл хэрэгжүүлсэн төрийн албан хаагчид аймаг тус бүрт амжилттай хэрэгжсэн бичил төслүүдийг өөрсдийн саналаар тодорхойлсныг дээрх хүснэгтэд нэгтгэн харуулж, амжилттай хэрэгжсэн нэг төслийн талаар шигтгээ оруулж тодотгов.

ШИГТГЭЭ

“Төв аймгийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд иргэдийн саналыг тусгахад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь” бичил төслийн баг иргэдээс авах саналын хуудсанд хүйсийн мэдээллийг тусган боловсруулж, бодлого төлөвлөлтөд ашиглаж хэвшсэн бөгөөд хүйсийн тэгш оролцоог хангахад хүйсийн харьцааны мэдээлэл чухал гэдгийг уг төслийн хүрээнд хийсэн судалгааны асуулгын үр дүн харуулсан байна. Ийнхүү жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт хийх чиглэлээр “харах өнцөг маань өөрчлөгдсөн” гэж эдгээр төрийн албан хаагчид дүгнэсэн байна.

Үүний зэрэгцээ хүйсийн тэгш байдлыг хангахад бодлого төлөвлөлтийг чиглүүлж, дүн шинжилгээ хийдэг болжээ. Бичил төслийн багийн гишүүд “Аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд дүн шинжилгээ хийж, хүйсийн зөрүүтэй байдлыг үндэслэлтэйгээр тодорхойлж, зөрүүг арилгахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж чадсан юм.

Энэ нь тэд хүйсийн зөрүүтэй байдлыг арилгах арга зүйд суралцаж, өдөр тутмын үйл ажиллагаандаа жендэрийн мэдрэмжтэй дүн шинжилгээ, төлөвлөлт хийж хэвшсэн нь “бидэнд сайн дадлага туршлага болж байна” гэх боломжийг олгожээ.

Түүнчлэн Төв аймгийн ЗДТГ-ын албан хаагчид 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт хийх, жендэрийн тэгш байдлыг хангахад чиглүүлж, боловсруулсан байна. Тухайлбал, 2023 оны төлөвлөгөөнд эрэгтэйчүүдийн гаргасан 114 санал, эмэгтэйчүүдийн гаргасан 269 саналыг тусган батлуулсан нь аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлтөд эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдсэнийг харуулж байгаа юм.

ЖМТ-ийн бичил төслийн багийн зүгээс 2023 оны төсвийн төсөлд 52 арга хэмжээнд 12.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тусгуулж, бичил төслөө 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжүүлж чадсан байна.

Бусад аймаг, сумдад сайн туршлага болгон түгээн дэлгэрүүлэх боломжтой гэж дараах амжилттай хэрэгжсэн бичил төслүүдийг нэрлэж болохоор байна.

Хүснэгт 11. Бусад аймаг, сумдад сайн туршлага болгон түгээн дэлгэрүүлэх боломжтой бичил төслүүд

Дундговь аймаг	Сүхбаатар аймаг	Төв аймаг
1.Уншигч эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх	1.Аймгийн ЗДТГ-ын эмэгтэй албан хаагчдын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх нь	1.Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд иргэдийн саналыг тусгахад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
2.Малжуулах хөтөлбөрт эмэгтэй малчдын оролцоог нэмэгдүүлэх	2.Байгууллагын дотоод журам, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг жендэрийн мэдрэмжтэй болгох нь	2.Морин хуур хөгжмөөр хичээллэх охидын тоог нэмэгдүүлэх
3.Гурвансайхан сумын ИТХ, ЗДТГ дахь зөвлөл, хороод, ажлын хэсэг дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх	3.Спортыг дэмжих орон нутгийн жендэрийн мэдрэмжтэй бодлого боловсруулах нь	3.Эрдэнэ МСҮТ-ийн малчны ангид суралцах эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх нь
4.Тэгш оролцоотой гэр бүл - Цэцэрлэг	4.Хоршооны зээлд эмэгтэйчүүдийн оролцоог хангах нь	4.Илүүдэл жингүй Угтаалын эмэгтэйчүүд
5.Байгаль хамгаалагч эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх	5.Байгаль орчны салбарт ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх замаар эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь	5.Хүүхдэд ээлтэй орчин

Эдгээр төслөөс жишээ болгон Дундговь аймгийн Малжуулах хөтөлбөрт эмэгтэй малчдын оролцоог нэмэгдүүлэх бичил төсөл, Сүхбаатар аймгийн Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн манлайлал, оролцоог нэмэгдүүлэх бичил төсөл, Төв аймгийн Эрдэнэ сумын МСҮТ-ийн сургуулийн малчны ангид эмэгтэй малчдыг хамруулах бичил төсөл-ийн мэдээллийг энэхүү тайланд хавсаргав (Хавсралт 4).



■ ДӨРӨВ. ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСӨВЛӨЛТИЙН БИЧИЛ ТӨСЛҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАРСАН ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ

Бичил төслийг хэрэгжүүлсэн багуудад тулгарсан нийтлэг хүндрэл, бэрхшээлийг нэгтгэн авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Төслийн зорилго, зорилтоо хэтэрхий томоор тодорхойлсон тул өөрсдөө нөлөөлөх боломжгүй болсон.
- Өөрийн ажил үүрэгтэйгээ холбож чадаагүй, өдөр тутмын үйл ажиллагаатай нь уялдаагүй, хэт том төсөвтэй төсөл хэрэгжүүлэхийг оролдсон;
- Хүйсээр ангилсан тоон мэдээлэл дутмаг;
- Зарим баг судалгааг ул суурьтай бодитой хийж чадаагүйгээс жендэрийн зөрүүтэй байдлыг сайн тодорхойлоогүй;
- Оны эхэнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй ажлыг хэрэгжүүлсэн.
- Төслийн бүх талын оролцогчид ижил түвшний мэдлэг, мэдээлэлгүй байснаас ойлголтын зөрүүтэй байдал үүссэн;
- Иргэдийн санал асуулгыг жендэрийн мэдрэмжтэй авч, үр дүнг нэгтгэн боловсруулах туршлага дутмаг;
- Төрийн албан хаагчдын үндсэн ажил үүрэгтэй давхар хэрэгжүүлж буй тул цаг төлөвлөлт, үйл ажиллагааны давхцал, ажлын ачаалал их байсан;
- Багийн гишүүдийн идэвх оролцоо хангалттай биш;
- Олон нийтийн өрөөсгөл хандлага, жендэрийн талаар ойлголт, мэдээлэл дутмаг
- Эмэгтэйчүүдийн идэвх оролцоо сул, хандлага сайнгүй;
- Бичил төслүүдийг хэрэгжүүлэхэд удирдах ажилтнуудын манлайлал, дэмжлэг харилцан адилгүй байсан;
- Салбар хоорондын хамтын ажиллагаа сул зэрэг хүндрэл, бэрхшээл хамаарна.

Тодруулбал, Дундговь аймгийн оролцогчид “15 сумаар тойрч явахад Төрийн хэмнэлтийн тухай хууль гарсантай холбоотойгоор төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төсвийн хувьд хязгаарлалт үүсэж байсан, мөн иргэдийн нийгмийн идэвх, оролцоо сул байгаа нь ажлын ахиц дэвшилд сөргөөр нөлөөлж байна” гэж үзсэн.

Харин Сүхбаатар аймгийн оролцогчид “Төсөл хэрэгжүүлэх эхний шатанд удирдлагын ойлголт, мэдлэг дутмаг байдлаас шалтгаалж, дэмжлэг үзүүлэх явц удаашрах, багийн гишүүдийн салбарын ялгаатай байдлаас шалтгаалан цаг төлөвлөлтийн зөрүүтэй байдал үүсэх, асуудлыг бүрэн тодорхойлох, судалгаа шинжилгээг бодитойгоор хийх болон жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр ойлголт, туршлага дутах, Төрийн хэмнэлтийн тухай хууль, санхүүгийн нөөц боломжоос шалтгаалах хүндрэл бэрхшээл учирсан” гэжээ.

Төв аймгийн оролцогчдын хувьд “иргэдийн жендэрийн хэвшмэл ойлголт хандлага, харалган байдал, жендэрийн суурь судалгаа бага байдгаас нөхцөл байдлын дүн шинжилгээ хийхэд их цаг зарцуулсан, иргэдээс санал авах боломжит хувилбаруудыг бүрэн сонгож чадаагүй, иргэдийн санал асуулгыг жендэрийн мэдрэмжтэй авч, үр дүнг нэгтгэн боловсруулах туршлага дутсан, зарим төсөлд хөрөнгө, санхүүгийн асуудал тулгарсан” зэрэг хүндрэл, бэрхшээл тулгарсан байна.



■ ТАВ. ЖМТ-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ХУРИМТЛУУЛСАН ТУРШЛАГА, СУРГАМЖ

Бичил төслийг хэрэгжүүлснээр хуримтлуулсан туршлага

- Иргэдээс авах саналын хуудсанд нас, хүйсийг тусган боловсруулж, санал авсан. Нас, хүйсийн мэдээлэл төсвийн төлөвлөлтөд маш чухал гэдгийг олж харсан.
- Жендэрийн мэдрэмжтэй дүн шинжилгээ хийснээр эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээ, шаардлагыг харгалзан үздэг болсон.
- Малчин эмэгтэйчүүдийг сургах сургалтын уян хатан, бодлого хөтөлбөртэй болсон.
- Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт сургалтад удирдах албан тушаалтнуудыг хамруулснаар бичил төслүүд амжилттай хэрэгжих нөхцөл бүрдсэн.
- Бичил төслүүд хэрэгжсэнээр охид, эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлж, сэтгэл зүйн дэмжлэг туслалцаа, зөвлөгөө мэдээлэл өгөх, соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээнүүд бий болсон.
- ТАХ-дын албан томилолтын зардлын талаарх суурь судалгаатай болсон, шийдвэр гаргагчдад зөвлөмж боловсруулсан.
- Салбар бүрд ЖМТ бичил төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх эхлэл тавигдлаа. Бичил төслийг хэрэгжүүлснээр: БИДНИЙ ХАРАХ ӨНЦӨГ ӨӨРЧЛӨГДСӨН. БИД МЭДЛЭГЭЭ УЛАМ БАТАТГАЖ ЧАДСАН гэж байв.

Шигтгээ

- *Дундговь аймгийн оролцогчид:* Эмэгтэйчүүдийг аливаа үйл ажиллагаанд оролцох, асуудал хэлэлцэх, шийдвэр гаргах зэрэгт тэгш, нээлттэй оролцуулах туршлагатай болсон, ЖМТ-ийн талаарх өөрсдийн мэдлэгийг байнга нэмэгдүүлж, удирдлага болон бусад албан хаагчид, ИТХ-ын Төлөөлөгчдөд сургалт, мэдээллийг тогтмол өгч ажиллах ёстой гэдгийг ойлгосон, мэдээллийг сумдаар явж газар дээр нь хүргэх нь эргэлзээ төрөх, буруу, дутуу ойлгохоос сэргийлэх, зөв мэдээллийг шууд хүргэдгээрээ сайн талтай, тэг төсөвтэйгөөр ажлыг хийж болдгийг ойлгосон.
- *Сүхбаатар аймгийн оролцогчид:* Салбар, орон нутаг, байгууллагын түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр төрийн албан хаагчдын ойлголт, мэдлэг сайжирсан, салбар, байгууллага, асуудал, арга хэмжээ бүрд жендэрийн мэдрэмжтэй хандах чиглэлээр тэмүүлэл хандлагатай болсон, төрийн байгууллага хоорондын болон олон улсын төсөл, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах сонирхол нэмэгдсэн, багууд харилцан суралцсан, хэрэгцээг зөв тодорхойлж чадвал боломж хаана ч байдаг гэдгийг мэдэж чадсан.
- *Төв аймгийн оролцогчид:* Иргэдээс авах саналын хуудсанд нас хүйсийг тусган боловсруулж, санал авдаг болсноор нас, хүйсийн мэдээлэл төсвийн төлөвлөлтөд маш чухал гэдгийг олж харсан, жендэрийн мэдрэмжтэй дүн шинжилгээ хийснээр эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээ, шаардлагыг харгалзан үздэг болсон, бичил төслүүд хэрэгжсэнээр охид, эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлсэн, салбар бүрд ЖМТ-ийн бичил төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх эхлэл тавигдсан, бичил төслийг хэрэгжүүлснээр “бидний харах өнцөг өөрчлөгдсөн” гэжээ.



Сургамж

Бичил төслийн санааг ЖМТ-ийн цахим болон танхимын сургалтад оролцогчид багаар ажиллах замаар гаргаж, орон нутагтаа хэрэгжүүлж буй тодорхой бодлого, хөтөлбөр, үйлчилгээг сонгон авч, сонгосон бодлого, хөтөлбөр, үйлчилгээний үр шим хүртэгчид болон төсвийн зарлагад сургалтын явцад авч үзсэн аргачлалын дагуу жендэрийн дүн шинжилгээ хийх замаар жендэрийн зөрүүтэй байдлыг тодорхойлсон юм. Ийнхүү жендэрийн зөрүүтэй байдал үүссэний ил, далд шалтгааныг үйлчилгээний хүртээмж, үйлчилгээ хүргэх байдал, нийгмийн үүрэг, санхүү, соёл уламжлал талаас нь илрүүлэн шинжилсний дүнд төрийн албан хаагчид өөрсдөө нөлөөлж чадах, богино хугацаанд, боломжит зардлаар нэгж, байгууллага, сум, аймгийн түвшиндээ хэрэгжүүлэх боломжтой ЖМТ-ийн бичил төслийг боловсруулж, түүнийгээ 3-5 сарын хугацаанд бие даан үр дүнтэй хэрэгжүүлж чадсан болно.

Нэгж, байгууллага, орон нутгийн түвшинд ЖМТ-ийн бичил төслийг хэрэгжүүлснээр төрийн албан хаагчид дараах сургамжийг авсан юм. Үүнд:

- Жендэрийн мэдрэмж, хүйсийн зөрүүтэй байдлыг зөв тодорхойлж, бичил төслийг хэрэгжүүлэх
- Жендэрийн харалган байдал нь тухайн байгууллагын соёлд нөлөөлж, үнэлэмжийг бууруулах эрсдэлтэй
- Жендэрийн зөрүүтэй байдлыг тодорхойлох шинжилгээг үндэслэлтэй хийхийн тулд хүйсээр ангилсан анхан шатны мэдээллийг сайтар цуглуулах
- ЖМТ-ийн бичил төсөл боловсруулж, хэрэгжүүлэх багийг зөв бүрдүүлэх
- Бичил төслийн санаа, хүрэх үр дүн, үйл ажиллагааг тодорхойлохдоо бодитоор хандах, өдөр тутмын үйл ажиллагаатайгаа уялдуулах
- Ажлын хамт олон болон удирдлагууддаа төслийн талаар дэлгэрэнгүй танилцуулан тэдний тусламж дэмжлэгийг авах, оролцоог хангах нь хамгийн чухал
- Сургалтаар олж авсан мэдлэгийг төсөл хэрэгжүүлэх замаар бататгах
- Холбогдох бусад байгууллагууд (төрийн болон орон нутгийн, ТББ, донор)-тай хамтран ажиллах замаар ЖМТ-ийн бичил төслийг үр дүнтэй хэрэгжүүлэн сайн туршлагыг бусдад түгээх
- Бичил төслийн багийн гишүүдийн үүрэг, оролцоо, идэвх санаачилга төслийн үр дүнд ихээхэн нөлөөтэй
- ЖМТ-ийн сургалт, зөвлөх үйлчилгээ, нөлөөллийн ажлыг өргөжүүлэн удирдлагын манлайллаар хангах
- Төсөл, хөтөлбөрийг жендэрийн мэдрэмжтэйгээр төлөвлөх, хамрах хүрээг зөв тодорхойлох
- Салбар хоорондын уялдаа, хамтын ажиллагааг бий болгох, төрийн албан хаагчдыг чадавхжуулах нь чухал гэдгийг ойлгожээ.

ЖМТ-ийн танхимын сургалтыг явуулж, бичил төслийн багуудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн сургагч багш нарын хувьд уг үйл ажиллагаанаас дараах сургамжийг авч үйлдэн суралцах замаар чадавхаа бэхжүүлж байна. Тухайлбал:

- ЖМТ-ийн бичил төслийн баг 1-6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан ч жендэрийн зөрүүтэй байдлыг үндэслэлтэй тодорхойлж, бичил төслөө



удирдамжийн дагуу боловсруулсан бол түүнийг хэрэгжүүлэхэд нь зөвлөн туслах цахим үйлчилгээг бичил төслийн баг тус бүрийн онцлогт тохируулан үзүүлж амжилтад хүргэх боломжтой.

- Зөвлөн туслах уулзалтын зорилго, агуулга, дараалал, үргэлжлэх хугацааг урьдчилан төлөвлөж, уулзалт бүрийн эхэнд нэг бүрчлэн танилцуулж, оролцогчид тухайн уулзалтын эзэд нь гэдгийг ойлгуулахын зэрэгцээ уулзалт, ярилцлагын үед багийн гишүүдийн, ялангуяа эмэгтэй, эрэгтэй гишүүдийн тэгш оролцоог хангахад сургагч багш анхаарч ажиллах
- Багууд бичил төслөө хэрэгжүүлэхэд нь туслахын тулд Үндэсний зөвлөхүүд ажиллаж байгаа гэдгээ ойлгуулж, тэдэнд хүндэтгэлтэй, эелдэг хандах
- Уулзалтад оролцогчид ямар зорилготой ирснийг асууж, хариулыг тодорхой авч тэдний хүлээлтэд нийцсэн зөвлөн туслах үйлчилгээг хүргэхэд анхаарах, өөрөөр хэлбэл, тухайн баг, оролцогчдын нөхцөл байдалд тохируулан зөвлөн туслах арга, техникийг хэрэглэх, шаардлагатай тохиолдолд бодит кейс, жишээ баримт, хөгжилтэй түүхийг зөв ашиглаж, дутагдалтай талаа өөрсдөө ойлгоход нь туслах
- Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхдээ бичил төслийн явц, төлөвлөж буй ажлыг нь яриулж, хэрэв тухайн бичил төсөл хэрэгжиж эхэлсэн бол түүнийг амжилттай хэрэгжүүлэхэд учирч болох эрсдэлийг тооцож, үр дүнтэй хэрэгжүүлж дуусгахад нь чиглэсэн зөвлөмжийг өгч, өөрсдийг нь хариуцлагажуулах
- “Төрийн албан хаагчид бол хийж байж л суралцана” гэдгийг суралцагчдад ойлгуулж, бичил төсөл боловсруулахын тулд зөвлөхүүдийн тодорхойлсон шалгууруудыг хангасан хөтөлбөрийг сонгон баримт нотолгоонд тулгуурлан ЖДШ хийх замаар жендэрийн тэгш бус байдал үүсэж буйг илрүүлэн ил, далд шалтгааныг нь “Шалтгаан-үр дагаврын диаграм” ашиглан тодорхойлж, төслийн үндэслэлээ гаргахад чиглэсэн аргачлалыг зөвхөн ЖМТ-ийн сургалт төдийгүй бусад төрлийн (төрийн ямар ч бодлогын үр нөлөөг үнэлэх) сургалтад ч ашиглах боломжтой болохыг дахин нотолж, туршин хэрэгжүүлж дадлагажив.
- Сургалт зохион байгуулснаас хойш тодорхой хугацааны дараа зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх нь сургалтын үнэлгээг сургагч багш өөртөө тавьж, үүнд тулгуурлан цаашид сургалтаа яаж сайжруулахыг шийдэхэд суралцлаа.
- Сургагч багш өөрийн санал, зөвлөмжийг оролцогчдод шууд хэлэхээс илүүтэй асуулт асуух арга барилд суралцах нь илүү үр дүнтэй, нөлөөтэй байдгийг ойлгож, практикт хэрэгжүүлэхийг хичээн ажиллаж байна.

ЖМТ-ийг нэвтрүүлснээр ажлын гүйцэтгэлд гарц буй ахиц

ЖМТ-ийн бичил төслүүдийг хэрэгжүүлснээр ажлын гүйцэтгэлд гарц буй ахиц, өөрчлөлтийг төсөлд хамрагдсан 3 аймгийн хувьд дараах байдлаар тодорхойллоо.

Дундговь аймаг:

- Эмэгтэйчүүдийн оролцоо аль ч түвшинд нэмэгдсэн.
- Аймгийн хөгжлийн дунд хугацааны бодлогын зорилтод удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийг бэлтгэх ажлыг тусгаж, хэрэгжүүлж эхэлсэн.



- Албан хаагчдын ЖМТ-ийн мэдлэг, ойлголт сайжирсан.
- ЖМТ-ийн талаарх өөрсдийн мэдлэгийг байнга нэмэгдүүлж, удирдлагууд болон бусад албан хаагч, ИТХ-ын Төлөөлөгч нарт сургалт явуулж, мэдээллийг тогтмол өгч ажилладаг болсон.
- Аливаа ажлын төлөвлөлтийг хийхдээ жендэрийн талаас байнга анхаарч тусгадаг болж байна.
- Багш, ажилчид, эцэг эхийн жендэрийн хэвшмэл ойлголт, мэдлэг, хандлага өөрчлөгдөж эхэлсэн.
- Гэр бүлийн тэгш оролцоо нэмэгдсэнээр бага насны хүүхэдтэй ээжүүд өөртөө цаг зарцуулах боломж нээгдсэн.

Сүхбаатар аймаг:

- Бодлого төлөвлөлтөд жендэрийн мэдрэмжтэй хандах хандлага нэмэгдэж байна, жишээлбэл, спортын салбарын удирдамж, шалгуур үзүүлэлт гэх мэт.
- Байгууллагын дотоод журам, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт жендэрийн тэгш байдалтай холбоотой арга хэмжээ, заалт шинээр тусгасан.
- Зорилтот бүлгийн эмэгтэйчүүд, 50-аас дээш насны, гэртээ хүүхдээ асарч буй ээжүүдийн нийгмийн идэвх оролцоо нэмэгдэж байна.
- Байгууллагын удирдлага, албан хаагчдын жендэрийн мэдлэг, хандлага эерэг болсон.

Төв аймаг:

- Аймгийн ХХААГ-т хэрэгжсэн бичил төслийн үр нөлөөгөөр Баянчандмань сумын ЗДТГ, Эрдэнэ сумын ЗДТГ, Эрдэнэ сумын МСҮТ, Эрдэнэ сумын цэцэрлэг, аймгийн ЗДТГ, ГБХЗХГ зэрэг байгууллагууд хүүхдийн өрөөтэй болж, сайн туршлагууд бусад сум, аймаг, төрийн байгууллагуудад нэвтэрч байна.
- Номын сангийн үйлчилгээ хүргэх, эмэгтэйчүүдийн фитнес клуб ажиллуулах, МСҮТ-д малчны анги байгуулах, санал асуулгад хүйсийг харгалздаг болох зэрэг бичил төслийг хэрэгжүүлснээр охид, эмэгтэйчүүдийн нийгэмд оролцох идэвх, оролцоо нэмэгдсэн.
- Морин хуурын дугуйлан, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч, жирэмсэн эхчүүдийн ар гэрт, жирэмсний хяналтын чанарыг сайжруулах чиглэлээр бичил төслийг хэрэгжүүлсний үр дүнд жендэрийн хэвшмэл ойлголтын нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа бий боллоо.
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний ялгаатай хэрэгцээг тусгах төслийг хэрэгжүүлснээр жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийг байгууллага, сум, аймаг, салбарын түвшинд хэрэгжүүлж эхэлсэн.
- Нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендэрийн эрх тэгш байдал, оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүмүүс тэгш хүртэх боломжийг бүрдүүлээ. Үүнд Эрдэнэ сумын МСҮТ-д нээсэн малчны анги, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, ойн нөхөрлөлийн гишүүдийн тэгш оролцоог хангах, ТАХ-дын албан томилолтын зардалд жендэрт суурилсан аудит хийж, зөвлөмж боловсруулах зэрэг бичил төсөлд голлох нөлөө үзүүлсэн.
- ЖМТ-ийн бичил төслийг хэрэгжүүлснээр төрийн албан хаагчдын жендэрийн харах өнцөг, хандлага өөрчлөгдөж байна.



Жендэрийн зөрүүтэй байдлыг арилгахад чиглэсэн бичил төслүүдийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр аймгууд төслийн багийн гишүүдийг чадавхжуулж, жендэрийн сургагчаар бэлтгэсэн, жендэрийн манлайлагчдын клубт идэвхтэй хамрагдсан, холбогдох бодлогын баримт бичиг, хөтөлбөр, журам, удирдамжид жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт, тайлагналын шалгуур үзүүлэлтүүдийг оруулсан, “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” цахим модуль сургалтад төрийн албан хаагчдыг хамруулах ажлыг өргөтгөж байгаа, өөрсдийн хэрэгжүүлсэн бичил төслийн сайн туршлагуудыг орон нутаг, байгууллага, төрийн албан хаагчид, иргэдэд сурталчлах зэрэг үйл ажиллагаа, арга хэмжээг хэрэгжүүлжээ.

Жендэрийн зөрүүтэй байдлыг арилгахад чиглэсэн бичил төслүүдийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх саналыг бичил төслийн багийн гишүүд санал болгож, аймаг тус бүр төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа юм. Үүнд:

1. Орон нутгийн болон төрийн байгууллагын удирдлага, албан хаагчдыг сургалт арга зүйгээр хангах: ЖМТ, ЖДШ+, ЖМ-тэй харилцаа холбоо гэх мэт цахим сургалтуудад хамруулж, эдгээрийг өдөр тутмын гарын авлага болгон ажилладаг болгох. Энэ хүрээнд:

- Төрийн байгууллага болон албан хаагчид, олон нийтэд жендэрийн ойлголт өгөх сургалт, уулзалтуудыг тогтмолжуулах
- Өдөр тутмын үйл ажиллагаандаа жендэрийн зөрүүтэй байдлыг арилгах талаар жендэрийн өнцгөөр харж санаачилга гарган ажиллах
- Төлөвлөлт болон төсвийн зарцуулалтад жендэрийн дүн шинжилгээ хийх

3. ЖМТ-ийг холбогдох бодлогын баримт бичиг, журамд тусган жишиг төслийн хүрээнд хэрэгжүүлсэн төслүүдийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх

4. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн бичил төслүүдийг тогтвортой хэрэгжүүлж, үр дүнг олон нийтэд сурталчлах нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх

5. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг тогтвортой хэрэгжүүлэх зорилгоор салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулж, удирдлагын манлайллыг нэмэгдүүлэх ажлууд хамаарна.

Ийнхүү оролцогчид чадавхжуулах сургалт, зөвлөх үйлчилгээнд хамрагдаж өөрсдийн эрхлэх ажлын хүрээнд жендэрийн зөрүүтэй байдлыг арилгах, хариу арга хэмжээ авах чиглэлээр суралцаж мэдлэг, ойлголтоо бататгаж, чадвараа дээшлүүлэв. Үүний зэрэгцээ суралцагчдын хувьд сургалтад хамрагдаж, зөвхөн бичил төсөл боловсруулж хамгаалаад орхих бус, тухайн төслөө амжилттай хэрэгжүүлж, үр дүнд нь хүргэхийн төлөө эцсийг нь хүртэл оролцож ажиллахаас гадна бичил төслийнхөө тогтвортой байдлыг хангах, өөрсдийн өдөр тутмын үйл ажиллагаандаа жендэрийн мэдрэмжтэй хандаж, ажлынхаа үр дүнг жендэрийн нүдээр харах чадвар, хандлагатай болох эхлэл тавигдсан гэж үзэж байна.



■ ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ, ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн цахим болон танхимын сургалт, зөвлөн туслах үйлчилгээ, бататгах сургалт, туршлага солилцох уулзалтыг зохион байгуулснаар цаашид жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар дараах санал, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

Төрийн албаны зөвлөлд:

- Төрийн албанд шинээр орж буй болон одоо ажиллаж буй төрийн албан хаагчдад жендэрийн эрх тэгш байдал, жендэрийн дүн шинжилгээ, жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсөвлөлтийн талаарх ойлголт, мэдлэгийг олгох чиглэлээр Удирдлагын академитай хамтарч ажиллах
- Төрийн албан хаагчдыг шалгаруулан авдаг шалгалтын агуулгад дээрх сэдвүүдээс тодорхой сорил, тестүүдийг оруулах замаар төрийн албан хаагчид жендэрийн мэдрэмжтэй ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх

Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт:

- ЗГХЭГ, яам, агентлаг, төрийн өмчит үйлдвэрийн газрууд болон холбогдох бусад байгууллагын боловсруулж, хэрэгжүүлдэг бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаа нь жендэрийн мэдрэмжтэй байдлаар төлөвлөгддөг болоход анхаарал хандуулах
- Энэ чиглэлд албан хаагчид, удирдлагуудын жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, дүн шинжилгээний мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлдэг тогтолцоог ЖҮХ, Удирдлагын академийн хамтран бий болгох
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн, бүтээмжийг дээшлүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулсан жендэрийн мэдрэмжтэй тусгай арга хэмжээ, үйл ажиллагааг төрийн албан хаагч, ажилтнууд гаргах идэвх санаачилгыг өрнүүлэх, өөрөөр хэлбэл, төрийн бүтээмжийг дээшлүүлэхдээ жендэрийн мэдрэмжтэй байдлыг давхар анхаарч үзэх
- Бусад улс орнуудын ЖМТ-ийн сайн туршлага болон орон нутагт MERIT төслийн хүрээнд хуримтлуулсан сайн туршлагуудаас харьяа яам, агентлаг, байгууллагууд суралцахад нь дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах

MERIT төсөлд:

- Бичил төслийн багуудын зүгээс эмэгтэйчүүдийн манлайллыг нэмэгдүүлэх арга хэмжээг төлөвлөх, хамтран ажилладаг аймгуудын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулахад нь MERIT төслөөс дэмжлэг үзүүлэх
- ЖМТ-ийн бичил төслүүдийн амжилтын түүхийг баримтжуулж, нийтэд түгээн дэлгэрүүлэх богино хэмжээний видео контент, шторк бэлтгэж, сайн туршлагыг сурталчлах
- ЖМТ-ийн цахим сургалтын 2, 3 дугаар багц (хэсэг)-ыг бүрэн дуусгаж, эхний сургалтад хамрагдаж, бичил төслөө амжилттай хэрэгжүүлсэн оролцогчдыг хамруулж, ЖМТ-ийн чадавхыг нь бэхжүүлэх

Жендэрийн үндэсний хороо, Сангийн яаманд:

- Салбар дундын болон орон нутаг хоорондын хамтын ажиллагааг хангах замаар үндэсний хэмжээнд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг тогтвортой хэрэгжүүлэх бодлогыг системтэй төлөвлөн, үр дүнд хүргэх механизмыг бүрдүүлж, манлайлж ажиллах
- ЖМТ-ийн бичил төслүүдийн үр дүн, сайн туршлагыг Удирдлагын академид бодлогын дэмжлэг үзүүлж хамтран ажиллах замаар бусад аймаг, салбар, орон нутагт танилцуулж, түгээн дэлгэрүүлэх ажлыг үндэсний зөвлөхүүд, салбарын болон орон нутгийн удирдах ажилтнууд, жендэрийн мэргэжилтнүүд, бичил төслийн багийн гишүүдийн оролцоотойгоор хэрэгжүүлэх
- MERIT төслөөс боловсруулж бэлтгэсэн ЖМТ-ийн цахим 1, 2, 3 дугаар багц сургалтыг төрийн болон орон нутгийн түвшинд ажиллаж буй төрийн албан хаагчид судлах замаар жендэрийн мэдрэмжээ нэмэгдүүлэх шаардлагыг тавьж ажиллах

Удирдлагын академид:

- Насанд хүрэгчдийн (практик хэрэгцээнд тулгуурласан) сургалтын болон зөвлөн туслах үйлчилгээний арга зүйг Академийн багш нарт эзэмшүүлэх чиглэлээр MERIT төсөлтэй хамтран жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт, үр дүнд суурилсан удирдлага, хяналт шинжилгээ, үнэлгээ, төслийн удирдлага, хүний нөөц, манлайллын чиглэлээр ажилладаг Канад багш нарын дэмжлэгийг авч хамтран ажиллах
- Орон нутагт MERIT төслөөс хэрэгжүүлсэн ЖМТ-ийн цахим, танхим хосолсон сургалтын үр дүнд бий болсон бичил төслийн сургамж, туршлага зэргийг тодорхой кейс, дасгал ажил болгон боловсруулах замаар төрийн албан хаагчдын зарим сургалтад авч ашиглах. Ингэхдээ жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, төсөвлөлт, жендэрийн дүн шинжилгээ зэрэг агуулгыг сургалтын хөтөлбөр, агуулгад оруулж эдгээр кейс, дасгалаар баяжуулах
- Дундговь, Сүхбаатар, Төв аймгийн төрийн албан хаагчдад зориулан зохион байгуулсан “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” сэдэвт цахим, танхим, зөвлөн туслах үйлчилгээг хослуулсан сургалтыг бусад аймаг, сумдын ИТХ, Засаг дарга, төсвийн байгууллагын дарга нарыг хамруулан зохион байгуулах, түүнчлэн MERIT төслийн хүрээнд хамтран ажилладаг аймгуудын бусад албан хаагчдыг энэ төрлийн сургалтад хамруулах
- Орон нутгийн бүх шатны ИТХ-ын Төлөөлөгч нарт жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн агуулгыг олгох богино сургалтын модуль боловсруулж, сонгууль бүрийн дараа шинээр сонгогдсон Төлөөлөгч нарт өгдөг байх боломжийг судалж, донор байгууллага, орон нутгийн удирдлагатай хамтарч ажиллах
- MERIT төслөөс боловсруулж бэлтгэсэн ЖМТ-ийн цахим 1, 2, 3 дугаар багц сургалтыг төрийн болон орон нутгийн түвшинд ажиллаж буй төрийн албан хаагчид судлах боломжийг олгож, Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалт болон бүх шатны сургалтад хамрагдаж буй төрийн албан хаагчид эдгээр сургалтад бүрэн хамрагдаж, сертификат авсан тохиолдолд кредит тооцдог болох



Аймаг, сумын Засаг дарга нар, ЗДТГ-т:

- MERIT төслийн баг болон Төв, Дундговь, Сүхбаатар аймгуудын ЗДТГ хамтран эдгээр бичил төслийг хэрэгжүүлсэн багийн гишүүд төслөө цаашид тогтвортой хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, тайланг нь хагас, бүтэн жилээр гаргуулж хяналт шинжилгээ, үнэлгээ хийхдээ харгалзан үзэж, амжилттай ажиллаж буй ТАХ-дад үр дүнгийн урамшуулал олгодог болох
- Аймаг, сумандаа амжилттай хэрэгжсэн ЖМТ-ийн бичил төслүүдийн үр дүн, сайн туршлага, сургамжийг орон нутаг, байгууллагуудын цахим хуудас, фейсбүүк группт мэдээлж үр дүнг нь баримтжуулж, бусад аймаг, нийслэл, сум, дүүрэгт түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах
- ЖМТ-ийн бичил төслүүдийг тогтвортой хэрэгжүүлэхийн тулд аймаг, сум, байгууллагын бодлогын баримт бичиг, дотоод журам, удирдамж зэрэгт тусгагдсан жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой заалтуудыг хэвээр хадгалж, мөрдөж ажиллах (өөрчлөхгүй байх буюу хүчингүй болгохгүй байх)
- Үндэсний статистикийн хорооноос баталдаг мал тооллогын А дансанд өрхийн тэргүүн болон өрхийн гишүүдийн нэрийг нэг бүрчлэн бичиж, хүйс болон регистрийн дугаартай нь бүртгэдэг болгох, мөн эрүүл мэнд, боловсрол, соёл, биеийн тамир, халамж, төрийн үйлчилгээний үр шим хүртэгчид, ажиллагчид, цалингийн сангийн мэдээллийг хүйсээр ангилсан байдлаар гаргах маягтыг батлуулах саналыг боловсруулж, холбогдох албан тушаалтанд хүргүүлэх

■ ДОЛОО. ЖМТ-ИЙН БИЧИЛ ТӨСЛҮҮДИЙГ ЦААШИД ТОГТВОРТОЙ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД УЧИРЧ БОЛОХ ЭРСДЭЛ, СОРИЛТ

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн цахим, танхимын сургалт, зөвлөн туслах үйлчилгээ, бататгах сургалт, аймгуудын туршлага солилцох уулзалтын явцаас харахад бичил төсөл боловсруулж, хэрэгжүүлсэн төрийн албан хаагчид цаашид ЖМТ-ийн бичил төслөө тогтвортой хэрэгжүүлэхэд нь дараах эрсдэл учирч болохоор байна. Үүнд:

- Өөрийн мэргэжил, хариуцдаг ажилтай хамааралгүй, эсвэл өөрөө нөлөөлж, хэрэгжүүлэх боломж багатай асуудлыг сонгосон зарим багийн гишүүд боловсруулж, хэрэгжүүлсэн бичил төслүүдээ ажил ихтэй, завгүй, миний хариуцах ажил биш гэх шалтгаанаар тогтвортой байдлыг хангаж ажиллахад оролцохгүй, хариуцлага хүлээхгүй байх хандлагатай байгаа нь ажиглагдсан.
- Бичил төслүүдийн хүрээнд дэвшүүлсэн зорилт, тусгасан тусгай арга хэмжээг цаашид тогтвортой хэрэгжүүлэхэд нь төсөв, санхүүгийн эх үүсвэр олдохгүй, батлагдахгүй байх, холбогдох албан тушаалтнууд шийдвэр гаргахгүй удааширах зэрэг хүндрэл учирч болох юм.
- Орон нутгийн сонгуулиар аймаг, сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, ЗДТГ-ын болон байгууллага, нэгжийн удирдах ажилтнууд солигдвол жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн бичил төслүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой шийдвэрийг холбогдох албан тушаалтан гаргахгүй байх, эсвэл батлагдсан бодлогын баримт, бичиг, журам, удирдамжийг өөрчлөх, хүчингүй болгох тохиолдолд зарим бичил төсөл тогтвортой хэрэгжихгүй байх магадлал нэмэгдэнэ. Иймээс цаашид эдгээр эрсдэлээс сэргийлэх тал дээр анхаарч ажиллах шаардлага үүснэ.



■ НАЙМ. ДҮГНЭЛТ

“Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” сургалтын эхний хэсэг болох “Нэгжийн түвшинд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэвтрүүлэх нь” сэдэвт 10 модуль бүхий цахим болон танхимын сургалтыг MERIT төслийн олон улсын зөвлөлтэй хамтран үндэсний зөвлөхүүд 2022 оны 6-р сард зохион байгуулав. Харин үндэсний зөвлөхүүд болон MERIT төслийн баг ЖМТ-ийн бичил төсөл боловсруулж, хэрэгжүүлсэн багуудад зөвлөн туслах үйлчилгээг бие даан үзүүлж, амжилттай хэрэгжүүлсэн болно. Энэ нь ЖМТ-ийн үндэсний чадавх бэхжиж эхэлж буйн илэрхийлэл юм.

Бичил төслийн багуудын боловсруулсан 35 төслийн 32 нь буюу 91.4 хувь нь амжилттай хэрэгжиж, эдгээр төслийн 97.5 хувь нь бүрэн хэрэгжиж, жендэрийн зөрүүтэй байдлыг бууруулах зорилгодоо хүрч чадсан байна.

MERIT төслөөс хэрэгжүүлсэн “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг орон нутгийн түвшинд нэвтрүүлэх жишгийг бий болгох” дэд төсөл нь аймаг, сумын түвшинд ажилладаг төрийн албан хаагчид харилцан суралцах, туршлагаа солилцох боломжийг олгож, зөвхөн нэгж, байгууллагын түвшинд ЖМТ-ийн бичил төслийг амжилттай хэрэгжүүлээд зогсохгүй орон нутаг, нийгмийн түвшин дэх жендэрийн зөрүүтэй байдлыг шинжилж, бууруулах чиглэлээр бодлого, тусгай арга хэмжээ хэрэгжүүлэх чадавхыг бий болгов. Төрийн албан хаагчид ийнхүү чадавхтай болсноор макро түвшний жендэрийн зөрүүтэй байдлыг том зургаар харж, түүнийг шийдвэрлэх эхлэлийг тавьсан гэж үзэх боломжтой. Хэрэв үндэслэл нотолгоотойгоор нэгж, байгууллагын түвшин дэх жендэрийн зөрүүтэй байдлыг тодорхойлж, шалтгааныг нь шинжилж, илрүүлж чадвал нэг ТАХ ч жендэрийн ялгаатай байдлыг үүсгэж буй томоохон асуудлыг шийдэж чадна гэдгийг энэ төсөл харууллаа.

Түүнчлэн жендэрийн практик хэрэгцээг шийдвэрлэх нь стратегийн сонирхлыг буюу орлого, хөрөнгийн зөрүүтэй байдлыг бүрэн арилгах боломжгүй гэдгийг ЖМТ-ийн бичил төсөл хэрэгжүүлсэн төрийн албан хаагч нар ойлгосны зэрэгцээ хамгийн чухал нь аймаг, суманд ажиллаж буй төрийн албан хаагчид орон нутаг, байгууллагынхаа өдөр тутмын ажлаа гүйцэтгэж, иргэдэд үйлчилгээ үзүүлэхдээ жендэрийн мэдрэмжтэй ханддаг болж, тэдний жендэрийн харах өнцөг, хандлага нь өөрчлөгдсөн явдал юм.



■ ЕС. ХАВСРАЛТУУД

Хавсралт 1: Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр Дорнод аймагт хэрэгжүүлж буй үйл ажиллагаа

№	Байгууллага	Ажил, албан тушаал, нэр	Хэрэгжүүлж буй үйл ажиллагаа
1.	Аймгийн Засаг даргын Тамгын газар (ЗДТГ)	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Э.Эрдэнэбилэг	<ul style="list-style-type: none"> - Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй хөтөлбөрүүдэд жендэрийн дүн шинжилгээ хийж, зөвлөмж боловсруулсан. - Аймгийн нийгмийн салбарын 6 чиглэлээр 2023 оны хэрэгжүүлэх бүх төслийн төсвийн задаргаанд үр шим хүртэгчдийг хүйсээр ангилж оруулсан. Жишээлбэл, Монгол бичгээ суръя төслийн Монгол хэл, бичгийн багш нарын чадварыг дээшлүүлэх арга хэмжээнд нийт 980 (үүнээс эмэгтэй 830, эрэгтэй 150) багш оролцоно гэх мэт.
2.	Аймгийн ЗДТГ	Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга В.Цэнгэлмаа	Харьяа агентлаг, сумдын ЗДТГ-ын ТАХ-ын цалингийн зардалд жендэрийн дүн шинжилгээ хийж, тайлан гаргасан.
3.	Аймгийн ЗДТГ	Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга М.Нямсүрэн	Дорнод Аймгийн хөгжлийн 2023 оны Хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа төсөл, хөтөлбөр арга хэмжээний үр шим хүртэгчдийн тоог гаргаж, хүйсээр ангилсан мэдээлэл оруулан боловсруулсан.
4.	Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар (ХХҮГ)	Хөдөлмөрийн хэлтсийн дарга А.Мягмарсүрэн	<p>1.ХХҮГ-ээс 2022 онд 7 хөтөлбөр, 28 арга хэмжээ хэрэгжүүлэхдээ жендэрийн мэдрэмжтэй заалтууд оруулсан. Жишээлбэл:</p> <ul style="list-style-type: none"> • “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн зөвлөгөө, мэдээлэл өгөх арга хэмжээний удирдамжид “Оролцогч 300 хүн (Жендэрийн тэгш байдлыг хангах)” гэх мэт заалтуудыг оруулж, жендэрийн мэдрэмжтэй болгосон. • Малжуулах арга хэмжээнд хамрагдсан өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийх, мал хүлээлцэх, тоног төхөөрөмж хүлээлцэх ажлын удирдамжид хүйсээр ангилсан мэдээлэл оруулсан. <p>Жишээлбэл, тухайн малчдыг үнэлэхдээ дараах үзүүлэлтүүдийг харгалзана гэж заажээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Малжуулах арга, хэмжээнд хамрагдсан өрх, өрхийн гишүүдийн тоо, хүйсээр ангилж үзүүлсэн байх - Уг хөтөлбөрт жендэрийн тэгш байдлыг хангах - Мал, маллаганы арга туршлага, аж ахуйн эрхлэлтийн үр чадвар олгох сургалтад хамрагдсан малчны тоо, хүйсээр - Малчин өрхийн гишүүдийг сургасан малчны тоо хүйсээр <p>Ингэснээр үнэлгээний баг хүйсээр ангилсан мэдээлэлд үндэслэн жендэрийн мэдрэмжтэйгээр хөтөлбөрийн оролцогчдыг сонгох боломжийг олгосон.</p> <p>2.Зарим тайлангийн нэмэлт заалтуудыг хүйсээр ангилж тайлагнасан. Жишээлбэл:</p> <ul style="list-style-type: none"> • Ажилд зуучилсан иргэдийн мэдээ • Бүртгэлтэй ажилгүй иргэний мэдээ • Бүртгэлтэй ажилгүй иргэний хөдөлгөөний мэдээ • Ажил хайгч иргэний мэдээ • Ажил хайгч иргэний хөдөлгөөний мэдээ гэх мэт.

5.	Аймгийн ХХҮГ	Мэргэжилтэн Х.Бат-Эрдэнэ	<p>MERIT төслийн жөндөрийн хэд хэдэн сургалтад хамрагдсаны дараа 2020 оноос байгууллагын Жөндөрийн ажлыг хавсран гүйцэтгэх болсон.</p> <p>Энэ хүрээнд дараах ажлуудыг хийсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Дорнод аймгийн ХХҮГ болон ажилчдын үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд 2023-2025 он хүртэл байгуулсан хамтын гэрээг жөндөрийн мэдрэмжтэй болгох үүднээс дараах заалтуудыг оруулсан. Уг гэрээний 3.8-д "Байгууллагын нийт ажилтны дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх бодлого, арга хэмжээг хүний нөөцийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ". 3.11-т "Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 62.1.3, 62.1.4 дэх заалтуудыг хэрэгжүүлэхдээ албан хаагчдын ажлын байрны нөхцөлийг дордуулахгүй, ялгаварлан гадуурхахгүй хэрэгжүүлнэ". 3.12-т "Хуулинд өөрөөр заагаагүй бол байгууллагад бүтцийн өөрчлөлт орохтой холбоотой харилцаанд ажлын байрны нэр заан, орон тоо хасагдахаас бусад тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй ажилтан, олон жил ажилласан эрэгтэй 58 нас, эмэгтэй 53 нас, өрх толгойлсон эцэг, эхийг ажлаас чөлөөлөхгүй байх, шаардлагатай тохиолдолд өөр ажил, албан тушаалд шилжүүлэх арга хэмжээ авах" гэсэн хэсгийг нэмж оруулсан. - Аймгийн ИТХ-аар батлагдсан 4 хөтөлбөр дээр 2021 оны үр шим хүртэгчдийг хүйсээр ангилан тусгасан. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Ахмадын ачлал 2021-2024 хөтөлбөр • Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр • Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дэд хөтөлбөр • Нэг өрх-Нэг ажлын байр хөтөлбөр (2021-2024). - Өөрийн ажлын 2022 оны тайлан болон 2023 оны төлөвлөгөөг үр шим хүртэгчээр илэрхийлж гаргаж байгаа. Жишээ нь, Дорнод аймгийн ахмад настны 2022 оны статистик мэдээллийг хүйсээр ангилж гаргасан. Мөн "Ахмадын ачлал 2021-2024" хөтөлбөрийн хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсвийн задаргаанд "Ахмад, залуучуудын дунд үндэсний уламжлалт ардын наадам, тэмцээнийг зохион байгуулж, улмаар зүүн бүсийн нэгдсэн арга хэмжээ болгоно" гэсэн зорилтын хүрээнд 3-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулна, нийт оролдогчдын тоо 500 (үүнээс эрэгтэй 150, эмэгтэй 350), 3,500,000 төгрөг зарцуулна гэх мэт. Мөн MERIT төслийн дэмжлэгтэйгээр 2022 онд ЖУХ-ны жөндөрийн сургагч багш болсон. Энэ хүрээнд ХХҮГ, Гадаадын иргэн, харьяатын газар, Хилийн цэргийн анги зэрэг байгууллагын 70 орчим төрийн албан хаагчдад жөндөрийн талаарх суурь ойлголт өгөх сургалт, хэлэлцүүлэг явуулсан.
----	--------------	-----------------------------	--



6.	Булган сумын ЗДТГ	ЗДТГ-ын дарга Б.Мөнгөнчимэг	<ul style="list-style-type: none"> - Бичил төсөл болох "Малжуулах" төсөл жөндөрийн мэдрэмжтэй хэрэгжиж байгаа. Энэ төсөлд хамрагдахдаа гэр бүлийн 2 гишүүн (эхнэр, нөхөр)-ийг оролцуулан гэрээ байгуулсны дараа малыг олгодог болсон. Ингэснээр олгосон мал нь зөвхөн нөхрийн өмч биш эхнэр, нөхрийн дундын өмч болж байгаа. - 2022 оны 11 сард Булган сумын ЗДТГ-ын Хөдөлмөрийн дотоод журмыг жөндөрийн мэдрэмжтэй болгон өөрчилсөн. Зарим заалтыг шинээр нэмж, зарим заалтад өөрчлөлт оруулсан. Жишээлбэл, 4.3 дахь заалтад "Амрах хооллох, нийтийн завсарлагаанаас гадна хүүхдээ хөхүүлэх, асрахад зориулан 1 хүртэлх настай хүүхэдтэй эх, ганц бие эцэгт (гэж нэмж оруулсан) 1 цагийн завсарлага нэмж олгоно. Завсарлагын хугацааг ажилласан цагт нь оруулж тооцно. 8.8-д "Тэтгэмж, тусламж, олговортой холбоотойгоор "Ажилтны эхнэр нь амаржиж хүүхэдтэй болсон бол 10 хоног хүртэл цалинтай чөлөө олгоно" гэсэн нэмэлт заалтыг шинээр оруулсан. - Булган сумын ЗДТГ-аас зохион байгуулж байгаа аливаа үйл ажиллагааны хөтөлбөрийн удирдамжийг жөндөрийн мэдрэмжтэй гаргадаг болж хэвшсэн. Зөвлөхийн хэлсэн шидэт тоо 50%, 50%-ийг хэрэглэдэг болсон. Жишээлбэл, <ul style="list-style-type: none"> • Булган сумын төрийн албан хаагчдын дунд зохион байгуулагдсан АСК-2022 тэмцээний оролцогч нарыг 4 эмэгтэй, 4 эрэгтэй төрийн албан хаагч (ТАХ) байхаар удирдамжид зааж өгсөн. • Хэрлэн голын жавар-2022 цас мөсний баярын удирдамжид 3 эмэгтэй, 3 эрэгтэй ТАХ байхаар заасан гэх мэт. - Булган сум ЗДТГ-ын төрийн албан хаагчдаа жөндөрийн талаар тогтмол чадавхжуулж байна, жишээлбэл, Жөндөрийн талаар "Өөрөөрөө үлгэрлэе" гарын авлагыг сумын 5 байгууллагад тараасан, Ахисан түвшний жөндөрийн дүн шинжилгээ сургалтад нэг ТАХ хамрагдсан, сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2022 оны Б/Г11 дүгээр тушаалаар "Жөндөр хариуцсан баг, ажилтан" томилогдсон. Эдгээр баг 32 багш, 64 сурагчдад жөндөрийн талаар сургалт явуулсан гэх мэт.
----	-------------------	-----------------------------	---

Хавсралт 2: Аймгуудад хэрэгжүүлсэн жөндөрийн зөрүүтэй байдлыг бууруулахад чиглэсэн бичил төслүүдийн жагсаалт

Дундговь аймагт хэрэгжсэн бичил төслүүд

№	Бичил төслийн нэр	Бичил төслийн				Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
		Зорилго	Төсөв, төгрөг	Хэрэгжилт, хувилар	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	
1.	Төрийн албаны удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх	- Дундговь аймгийн хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийг тодотгож, удирдах албан тушаалд эмэгтэй ТАХ томилогдох нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн заалтыг нэмж оруулах - Удирдлагын академийн ахлах болон эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад эрэгтэй, эмэгтэй албан хаагчдын тоог тэнцүү байхаар квот тогтоосон заалт оруулах	10,000,000	100%	1. Бичил төслийн мэдээллийг аймгийн удирдлагуудад албан ёсоор танилцуулсан. 2. Удирдлагын академид 11 төрийн албан хаагч суралцсаны 9 нь эмэгтэй ТАХ хамрагдсан. Ингэснээр тэд цаашид удирдах албан тушаалд дэвшихэд нь дөхөм болно. 3. Нөлөөллийн арга хэмжээ явуулсны дүнд хэлтэс, албадын дарга нарын бүтцэд өөрчлөлт орсон. Аймгийн ЗДТГ-т 1 эмэгтэй удирдах албан тушаалтан байсан бол 3 эмэгтэй удирдах албан тушаалтантай болсон.	
2.	Байгаль хамгаалагч эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх	Байгаль хамгаалагч эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх, ажиллах орчин, нөхцөл боломжөөр хангах, эрүүл мэндийг хамгаалах	200,000	100%	1. Ажлын байрны тодорхойлолтод дүн шинжилгээ хийхэд зөрүүтэй байдлыг бий болгох заалт байгаагүй. 2. Ажиллах орчны судалгааг явуулж эмэгтэйчүүд ажиллахгүй байгаагийн шалтгааныг тодруулсан. Мөн шаардлагатай зүйлсийг нь тодорхойлсон. 3. БОАЖ-ын сайдын А451 тушаалаар байгаль хамгаалагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаарх тушаалд 2 заалтыг нэмж жөндөрийн зөрүүтэй байдлыг арилгахад чиглүүлсэн. Ингэснээр 21 аймагт хэрэгжинэ. Олон нийтэд байгаль хамгаалагчийн ажлыг таниулах үйл ажиллагааг эмэгтэй байгаль хамгаалагчтай хамтран ЕБС-ийн 12-р ангийнханд зохион байгуулсан.	



3.	Гурвансайхан сумын ИТХ-ын зөвлөл, хороод дахь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх	Сумын ИТХ-ын зөвлөлийн бүрэлдэхүүн, хороодын дарга нарын жендэрийн зөрүүтэй байдлыг арилгаж тоог тэнцвэржүүлэх	0	100%	<p>1. Гурвансайхан сумын ИТХ-ын зөвлөлд жендэрийн тэгш оролцоог хангах талаар ИТХ-ын даргад танилцуулж, 43 тоот тушаалаар зөвлөлийг шинэчлэн баталж, зөвлөлийг 4 эрэгтэй, 3 эмэгтэй төлөөлөгчтэйгөөр байгуулсан.</p> <p>2. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар Сумын ЗДТГ-ын нийт ажилчдын хурлаар 7-р сард хэлэлцэж, дотоод журамдаа 3 заалтыг нэмж оруулан баталсан.</p> <p>3. Ажлын хэсгийг томилохдоо жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар анхаарч, байгуулагдсан 2 ажлын хэсэгт жендэрийн харьцааг анхаарч ажиллаж эхэлсэн.</p> <p>4. Ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ мөн жендэрийн тэгш байдлыг хангаж ажиллаж эхэлсэн.</p> <p>5. ЖМТ-ийн сургалтыг 11 сарын 3-нд ИТХ-ын 5 төлөөлөгч, ЗДИГ-ын 10 ажилтанд явуулж, АХА тэмцээн зохион байгуулсан.</p> <p>6. Эмэгтэй төлөөлөгчид, ЗДТГ-ын ажилтан нийт 12 эмэгтэйчүүдийн дунд асуулга явуулж үр дүнгээ нэгтгэсэн.</p>
4.	Малчин өрхийн жендерийн хэвшмэл байдлыг өөрчлөх	Гэр бүлийн хүрээнд эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах оролцоог нэмэгдүүлж, өмч болон орлоготой болох талаар сургалт мэдээлэл, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, санал санаачилга гаргуулах, төрөөс олгож буй түүхий эдийн урамшууллыг гэр бүлийн хамтарсан дансанд төвлөрүүлэх	0	100%	<p>1. Малчдад (гэр бүлийн хамт) жендэрийн талаар сургалт мэдээлэл хийх</p> <p>2. Эмэгтэй хүний нийгмийн оролцоог ойлгуулах</p> <p>3. Ноос, ноолуур, түүхий эдийн урамшууллыг нөхөр, эхнэрийн хамтран эзэмшдэг дансаар авах талаар санаачилга гаргуулах</p> <p>4. Зорилтот өрхүүдийг хамтран эзэмшигч данстай болгож зөвлөн туслах ажлыг зохион байгуулах</p>
5.	Тэгш оролцоотой гэр бүл - Цэцэрлэг	Бага насны хүүхдийн хөгжилд эцэг эхийн тэгш оролцоог хангах	60,000	100%	<p>1. 8-р сараас суурь судалгааг хийж эхэлсэн. Тоо баримт цуглуулсан. Эрчүүд 14, эмэгтэйчүүд 85%-тай оролцсон. 14% нь эцэггүй, тавиул хүүхдүүд байв.</p> <p>2. Нээлттэй өдөрлөгийг 42 гэр бүлийн дунд зохион байгуулахад 28.5% нь эрэгтэйчүүд байв.</p> <p>3. Гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулахад 37.5% нь эрэгтэй, бөхийн барилдаан хүүхдүүдийн дунд зохиоход 64% нь аавууд ирсэн.</p> <p>4. "Үлгэрч гэр бүл" ажлыг зохион байгуулж, аавуудаар хүүхдүүдэд үлгэр яриулсан.</p>

6.	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар орлогыг нь нэмэгдүүлэх	Баянжаргалан суманд үрсэлгээний талбай бий болгох, мод тарихад эмэгтэйчүүдийн оролцоог хангаж, орлогыг нь нэмэгдүүлэх	23,300,000	100%	<ol style="list-style-type: none"> 1. Сумандаа чацарганын 1 га талбайтай болж хашаа барьсан 2. Хашааг хийхдээ 20 хүнийг ажиллуулахад 11 эмэгтэйг ажиллуулж, Хөдөлмөр эрхлэлтийн сангаас 10 сая төгрөгийн цалин олгосон. 3. Худагтай болсон. 4. Туулай, шувуунаас хамгаалах тор зэргийг татсан. 5. Ажилгүй 11 эмэгтэй (өрх толгойлсон 2, хөгжлийн бэрхшээлтэй иргэн асардаг 2) хамрагдсан, эдгээр нь нэмэлт орлоготой болсон. 6. Зорилт 3-ын хүрээнд мэргэжлийн хүнээр 3 удаагийн сургалт, мөн олсон орлогоо тооцох, хүнсний ногоо тарих сургалтуудыг явуулсан.
7.	Мянгат малчдын зөвлөгөөнд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх	Мянгат малчдын жөндөрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх	1,050,000	100%	<ol style="list-style-type: none"> 1. 2019 оны мянгат малчдын үүлзалтад 70 хувь нь эрэгтэйчүүд оролцсон бол 2022 оны өдөрлөгт оролцсон 210 хүний 47.6% нь эрэгтэй, 52.4% нь эмэгтэй болж хүйсийн харьцаа ижил тэгш байхаар зохион байгуулсан. 2. “Тогтвортой гэр бүлийн үндэс” сургалт, жижиг тэмцээн явуулж урамшуулсан. 3. Жөндөрийн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, сургалтаар иргэдийн жөндөрийн хэвшмэл ойлголтыг залруулах мэдээллийг үр дүнтэйгээр өгсөн. 4. Спорт өдөрлөгөөр 3 төрөлт тэмцээнийг зохион байгуулж байр эзлүүлж урамшуулсан. 5. Урлагийн тоглолт хийж, үдшийн цэнгүүнд караоке дууны тэмцээнийг зохион байгуулж хүйсийн харьцааг тэгш байхаар оролцуулан байр эзлүүлж шагнасан, 6. Хамтрагч байгууллага Хаан банкнаас “эдийн засгаа зөв удирдах, хадгаламж үүсгэхийн ач холбогдол” сургалтыг зохион байгуулсан.



8.	Уншигч эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх	Иргэдэд орон зай, цаг хугацаа хамаарахгүйгээр номын сангийн үйлчилгээг эмэгтэйчүүдэд тэгш, хүртээмжтэй хүргэх	0	100%	<ol style="list-style-type: none"> 1. Судалгаа хийсэн. Гэрээр ном уншиж буй эмэгтэйчүүд нь уншлагын танхимаар үйлчлүүлэгчдээс илүү байв. 2. Дэлгэрхангай суманд зөөврийн номын санг ажиллуулсан. Бусад 2 сумтай холбогдож ийм байдлаар зөөврийн номын сангийн үйлчилгээ явуулна гэж ярьсан. 3. Мандал худалдааны төвийн 120 ажилтны 101 нь эмэгтэйчүүд. Урьд нь 3 эмэгтэй л номын санд очиж байсан. Одоо 21 эмэгтэй зөөврийн номын сангаар үйлчлүүлэх болсон. Аймгийн хэмжээнд болон, Өлзийт, Хулд суманд энэ туршлагыг нэвтрүүлэх талаар Санамж бичгийг 11 сарын 20-нд байгуулсан. Номын хандив, цахим номын сангийн хөрөнгө оруулагчаа олох талаар нутгийн зөвлөлтэй хамтарч байна.
9.	Малжуулах хөтөлбөрт эмэгтэй малчдын оролцоог нэмэгдүүлэх	Эмэгтэй малчдын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх (18-45 насны 0-150 хүртэл малтай)	0	100%	<ol style="list-style-type: none"> 1. Сумдын хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтнүүдэд албан тоотоор малчин өрхийн хөтөлбөрийн анхан шатны төслийн шалгуур үзүүлэлт, танилцуулгад эмэгтэй малчдыг хамрагдах боломжтой байдлаар зохион байгуулахыг чиглэл болгосон. Энэ дагуу шалгуур үзүүлэлтэд өөрчлөлт оруулсан 2. Амьжиргааг дэмжих сумдын зөвлөлийнхөнд жөндөрийн эрх тэгш байдлыг хангах талаар ойлголт өгсөн. 3. 10 сумын удирдлагуудад шалгуурт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг ЖМТ-ийн сургалттай хамт өгсөн. 4. Малчдын зээлд хамрагдахаар 50 иргэн төслөө ирүүлснээс 26 төсөл шалгарч 130 сая төгрөг зарцуулсан. Үүний 2 нь өрх толгойлсон эмэгтэй. Энэ нь өмнөх онуудаас нэмэгдсэн дүн юм.

Сүхбаатар аймагт хэрэгжсэн бичил төслүүд

№	Бичил төслийн нэр	Бичил төслийн			
		Зорилго	Төсөв, төгрөг	Хэрэгжилт, хувиар	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
1.	Бүсгүйн гараа	Гэртээ хүүхдээ хараад сууж байгаа, ажлаасаа түр хугацаагаар чөлөө авсан, сургууль төгсөж ирээд харахан ажлаа олоогүй байгаа 20-35 насны, нийгмийн харилцаанд оролцох сонирхолтой, өөрийгөө хөгжүүлэх чин хүсэлтэй бүсгүйчүүдийн хувь хүний үр чадвар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх замаар идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх, өөрчлөлтийг манлайлах үр чадвар олгоно.	1,500,000	100%	<p>1. Төслийн зорилтот бүлэгт тохирох 20 бүсгүйг сонгон авч 3 долоо хоногийн сургалтад хамруулсан. Сургалтын агуулга хувь хүний үр чадвар, манлайлыг хөгжүүлэх чиглэлээр, 40 дэд сэдвийн хүрээнд заагдсан. Хөтөлбөр танхимын хичээл, онлайн уулзалт, мэдээлэл, дадлага ажил, илтгэл, хэлэлцүүлэг, зоочинтой ярилцлага зэрэг хэлбэрээр зохион байгуулагдсан.</p> <p>2. Сургагч багш болон зочин, ментороор Сүхбаатар аймгийн салбар бүрээс урьж оролцуулсан. Энэ нь орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой юм.</p> <p>3. 4 дэх долоо хоногт бүсгүйчүүд 4 баг болон хуваагдаж яг энэ төслийн зорилготой нийцэхүйц охид эмэгтэйчүүдийн оролцоо, манлайлыг дэмжсэн нөлөөллийн аян, бичил төслийг бичиж идэвх оролцоог дэмжиж уриалах юм.</p> <p>4. Харин 5 дахь долоо хоногт бүсгүйчүүд төслөө санхүүжүүлэгч шаркуудад танилцуулна. Шаркууд өөрсдийн итгэл үнэмшил, хүлээж буй үр дүнд нийцсэн төслийг ивээн тэтгэж хамтран ажиллана.</p>
2.	Хоршооны зээлд эмэгтэйчүүдийн оролцоог хангах нь	Зээлд хамрагдах эмэгтэй бизнес эрхлэгчдийн тоог нэмэгдүүлэх	0	100%	<p>1. Сүхбаатар аймгийн "Баялаг бүтээгчдийн холбоо"-той хамтран хоршооны зээл авах сонирхолтой бизнес эрхлэгчдэд цахим сургалт зохион байгуулсан.</p> <p>2. 2013-2022 оны хооронд Сүхбаатар аймгийн Наран сумын сум хөгжүүлэх сан, хоршоог дэмжих сангийн зээл олголт, буцаан төлөлтийн байдалд баримт бичиг үндэслэн судалгаа хийсэн. Аймгийн ХАА-н газрын Хоршоо хариуцсан мэргэжилтэн Баттуяа хоршоо хөгжүүлэх сангийн журмын талаар сургалт зохион байгуулсан.</p>
3.	Эмэгтэйчүүдийн үр чадварыг дээшлүүлж, ерхийн орлогыг нэмэгдүүлэх нь	Эмэгтэйчүүдийн үр чадварыг дээшлүүлэх, ерхийн орлогыг нэмэгдүүлэх	0	100%	<p>1. Сонгогдсон эмэгтэйчүүдэд оёдол эсгүүр, гар урлалын сургалтыг аймгийн төв дээр зохион байгуулсан.</p> <p>2. Хөгжлийн бэрхшээлтэй 6 эмэгтэйг хамруулсан, таван эмэгтэйд санхүүжилт олгосон.</p> <p>3. Оёдол эсгүүрийн сургалтад хамрагдсан эмэгтэйчүүдийн хийсэн гар урлалын бүтээлээр үзэсгэлэн гаргаснаар үр дүн гарна гэж үзэж байгаа.</p>



4.	Аймгийн ЗДТГ-ын эмэгтэй албан хаагчдын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх нь	Төрийн захиргааны албан хаагч эмэгтэйчүүдэд санхүүгийн боловсрол олгох	0	100%	<ol style="list-style-type: none"> 1. Төлөвлөгөө гаргасан 2. Суурь судалгаа авсан 3. Групп чат үүсгэсэн 4. "Эртэч бүсгүйчүүд" уулзалт зохион байгуулсан 5. Нөлөөллийн ажлууд хийсэн 6. Өрхийн санхүүгээ удирдах, хөрөнгө оруулалтын арга хэрэгслүүдийн ялгаа, эрсдэлийн талаар мэдээлэл өгсөн 7. Өрхийн санхүү хөтлөх дэвтэр, хөрөнгийн зах зээлийн ном олгосон.
5.	Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт эмэгтэй байгаль хамгаалагчдын тоог нэмэгдүүлэх нь	БНХМН-ийн гишүүн эмэгтэйчүүдийг мэдээллээр хангах, ур чадвар олгож чадавхжуулах. Байгаль орчинд ээлтэй, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэнээр орон нутгийн эмэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн ногоон ажлын байрыг бий болгож, тэдний ашиг орлогыг нэмэгдүүлнэ.	3,000,000	100%	<ol style="list-style-type: none"> 1. Эмэгтэй байгаль хамгаалагчийн ажлыг сурталчилсан "Миний ажил миний бахархал" контент нэвтрүүлэг хийсэн. 2. Дарьганга, Мөнххаан, Баруун-Урт сумын Эко клубын суралтдад "Залуу байгаль хамгаалагч" хөтөлбөрийн хүрээнд байгаль хамгаалагчийн ажлын онцлог, эмэгтэй хүн байгаль хамгаалагчаар ажиллахын давуу тал, байгаль орчны салбар дахь жендерийн зөрүүтэй байдал сэдвээр сургалт 3 удаа хийж давхардсан тоогоор 200 орчим хүн хамрагдсан. 3. Зүүн бүсийн аймгуудын удирдлага, БОАЖГ, ХХААГ, БСШУГ, ГХБХБГ-ын мэргэжилтнүүд болон 24 сумын эко клубын багш, суралчид зэрэг нийт 130 хүн оролцсон чуулга уулзалтад эмэгтэй байгаль хамгаалагчийн ажлыг сурталчилсан сургалт хийж, уриалга гаргасан. 4. Байгаль хамгаалагчийн 3 ажлын байрны сул орон тоог хүйс заахгүйгээр зарлуулсан. 5. Хээрийн аялал 3, Цахим сургалт 1-ийг тус тус хийсэн.
6.	Соёл ба жөндөр	Дотоод журамд жендерийн мэдрэмжтэй нэмэлт заалт оруулан хүртээмжийг нэмэгдүүлэх	0	100%	<ol style="list-style-type: none"> 1. Дотоод журамд дүн шинжилгээ хийсэн 2. Төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийсэн 3. Хамт олонтой уулзалт зохион байгуулсан 4. Хамт олонд жендерийн анхан шатны ойлголт мэдээлэл өгсөн 5. Асгат сумын соёлын төв дотоод журамд нэмэлт заалт оруулж мөрдөж эхэлсэн.
7.	Зорилготой бүлгийн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь	50-аас дээш насны эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих. Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамруулах, нийгмийн идэвхийг нэмэгдүүлэх	0	70%	<ol style="list-style-type: none"> 1. ИТХ-д нөлөөллийн судалгаа хийсэн 2. Байгууллагууд хоорондын уялдаа холбоог сайжруулж, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх нөлөөллийн уулзалт зохион байгуулсан.
8.	Байгууллагын дотоод журам, ТАХ-дын нийгмийн баталгааны хөтөлбөрийн жендерийн мэдрэмжтэй болгох нь	Хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт оруулж, нийгмийн баталгаа хангах хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, сургалт явуулж, зөвлөх үйлчилгээгээр хангах	0	100%	<ol style="list-style-type: none"> 1. Төрийн албан хаагчдад үзүүлж буй нийгмийн баталгаа хүртээмжтэй эсэхэд дүн шинжилгээ хийсэн 2. Төрийн албан хаагчдад үзүүлж буй нийгмийн баталгаа хүртээмжтэй эсэхэд дүн шинжилгээ хийсэн

9.	Мэргэжлийн боловсрол эзэмшиж буй охидын тоог нэмэгдүүлэх нь	МСУТ-ийн оюутны жендэрийн харьцааг тэнцвэржүүлэх, эмэгтэй төгсөгчдийг ажлын байраар хангах	0	100%	<ol style="list-style-type: none"> 1. МСУТ-ийн суралцагчдын сүүлийн 10 жилийн статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн 2. Сургуулийн удирдлагуудтай уулзалт хийсэн. 3. Ойжуулагчийн мэргэжлийг судалж, ойн инженерээр охидыг сургахаар төлөвлөгөөнд оруулсан. 4. Олон нийтэд, ялангуяа 10 жилийн хүүхдүүдтэй уулзахдаа мэргэжилд хүйс байхгүй гэдэг ойлголтыг өгөхийг зорьсон..
10.	Нийгмийн даатгалын хэлтсийн эмэгтэй ТАХ-ийн нийгмийн баталгааг нэмэгдүүлэх	Эмэгтэй ТАХ-дыг ахин дэвших эрх зүйн чадамжийг нэмэгдүүлэх, нийгмийн баталгааг нь сайжруулах	0	100%	<ol style="list-style-type: none"> 1. Ажлын байранд ээлжийн амралтын үед ажиллаж байгаа 5 эмэгтэй албан хаагчдад туршиж үзсэн 2. Байгууллагын даргад болон хамт олондоо бичил төслийн талаар мэдээлэл өгч, саналыг нь авсан 3. Ганцаарчилсан ярилцлагыг 4 эмэгтэй албан хаагчтай хийсэн.
11.	Спортыг дэмжих орон нутгийн жендэрийн мэдрэмжтэй бодлого боловсруулах нь	Спортоор хичээллэгчдийн жендэрийн харьцааг тэнцвэржүүлэх	0	100%	<ol style="list-style-type: none"> 1. Асгат сум болон аймгийн түвшинд зохион байгуулагдах тэмцээн уралдааны удирдамжид дүн шинжилгээ хийсэн. 2. Аль болох тэмцээнд оролцогчдыг хүйсийн тэнцвэрт харьцааг хангахад чиглүүлсэн. 3. Макро түвшинд жендэрийн зөрүүтэй байдлыг арилгах чиглэлээр уулзалт нөлөөллийн үйл ажиллагаа хийсэн. Үүнд: спортыг дэмжих арга хэмжээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшний тоон мэдээллийг хүйсээр гаргаж, хүйсийн тэнцвэрт байдлыг хангахад чиглүүлсэн.



Төв аймагт хэрэгжсэн бичил төслүүд

№	Бичил төслийн нэр	Бичил төслийн			
		Зорилго	Төсөв, төгрөг	Хэрэгжилт, хувьар	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
1.	ХЭДС-аас олгож байгаа аж ахуй эрхлэгчдийг дэмжих санхүүгийн дэмжлэгийг жендэрийн мэдрэмжтэй хуваарилах	Өрхийн үйлдвэрлэл эрхлэгч эмэгтэйчүүдийг зээлд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх	0	100%	Өрхийн үйлдвэрлэл эрхлэгч эмэгтэйчүүдийг чадавхжуулах, төсөл бичих аргаар сургалтад хамруулж, төслийг нь сонгон шалгаруулалтад оруулж санхүүжилт олгож, бусадтай нь туршлага солилцсон. 55 иргэнд 437 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Тэдний 36 нь эмэгтэй, 290 сая төгрөг олгосон.
2.	Албан томилолтын зардалд жендэрт суурилсан аудит хийх	Эмэгтэй ТАХ-дыг албан томилолтоор явах адил боломжоор хангах	0	100%	Аймгийн хэмжээний 27 сумын ИТХ, ЗДТГ, аймгийн ИТХ, ЗДТГ, нийт 56 нутгийн удирдлагын байгууллагын нийт ажиллагсдыг удирдлагын болон гүйцэтгэх албан тушаал, цалин хөлс, олгосон томилолтын зардлаар нь хүйсээр ангилсан судалгааг 2021 он, 2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр хийсэн. Дотоод аудитаар мэргэшсэн хүний нөөц дээр тулгуурлан хийсэн. Аудит хийгдсэн байгууллагадаа "Зөвлөмж" өгөхөөр бэлтгэж байна.
3.	Морин хуур хөгжмөөр хичээллэх охидын тоог нэмэгдүүлэх	Морин хуурын хөгжмөөр хичээллэх эмэгтэй сурагчдын тоог 50%-аар нэмэгдүүлэх	0	100%	Охид морин хуур хөгжмөөр хичээллэж болно гэдгийг ойлгуулах сургалт, сурталчилгаа хийсэн. Морин хуур хөгжмөөр хичээллэх хүсэлтэй охидын судалгааг гаргасан. Морин хуур хөгжмөөр хичээллэж чөлөөт цагаа өнгөрүүлэх байр (дотуур байр, соёлын төв, хүүхэд хөгжлийн өрөө)-аар хангасан. Эмэгтэй сурагчдыг морин хуур хөгжмөөр хичээллүүлэх, эрэгтэй сурагчдын хамт хүндэтгэлийн тоглолт арга хэмжээнд оролцуулах, тайлант өдөрлөг зохион байгуулна. Соёлын төвийн хөгжмийн өрөөнд мягмар, пүрэв гарагт 11-13, 16-18 цагийн хооронд морин хуур хөгжмөөр хичээллэх цагийн хуваарь гарган мөрдөн ажиллаж байна. Морин хуур хөгжмөөр хичээллэх хүсэлт гаргасан 30 сурагчийг морин хуурын дугуйланд хамруулж байна. Үүнээс 15 нь эмэгтэй сурагч.

4.	Эрдэнэ МСУТ-ийн малчны ангид суралцах эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх нь	Жендэрийн тэгш эрхийг хангах, эмэгтэйчүүдийн оруулж буй хувь нэмрийг хүлээн зөвшөөрөхийн тулд малчин эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд тэгш үр шим хүртээх боломжийг бүрдүүлэх	0	100%	Малчны мэргэжлийг сурталчилсан шторкийг ХМХ-ээр нэвтрүүлсэн. Малчны ангийн сургалтын уян хатан бодлогыг хэрэгжүүлсэн. Элсэлтийн журамд нэмэлт оруулж малчны ангийн элсэлтийн 50 хувьд эмэгтэйчүүд байхаар заалтыг шинээр оруулсан. Урлаг спортын арга хэмжээг сар бүр зохион явуулах график гаргаж баталсан. Шатлан суралцах боломжийг нээж өгсөн. Цаашдаа дүйцүүлэн сургаж боломжийг нээнэ. 2022-2023 оны хичээлийн жилд нийт 30 оюутан элсүүлснээс 16 эмэгтэй, 14 эрэгтэй суралцагч байна. Эмэгтэйчүүдийн эзлэх хувь 53 хувьтай байна.
5.	Соёлын биет бус өвийн эмэгтэй өвлөн уламжлагчийг илрүүлж, нэмэгдүүлэх	Ягтуур соёлоо хадгалж хамгаалах, хойч үедээ өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх, эмэгтэй өвлөн уламжлагчийн тоог нэмэгдүүлэх (50 хувьд хүргэнэ)	0	80%	Суурь судалгааг шинээр бий болгох ажлыг зохион байгуулсан. Соёлын биет бус өвлөн уламжлагчдын бодит тоог гаргаж, тэдний эзлэх хувь, эр, эм өвлөн уламжлагчдыг нарийвчлан гаргаж, сурталчлах ажлыг хийсэн.
6.	Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд иргэдийн саналыг тусгахад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх	Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд жендэрийн дүн шинжилгээ хийж, иргэдийн саналыг авч, тусгахад жендэрийн тэгш байдлыг бий болгох	0	100%	Иргэдээс авах саналын хуудсанд нас хүйсийг тусгаж, саналыг нь авсан. 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд жендэрийн дүн шинжилгээ хийсэн. Иргэдийн саналыг тусгасан хөгжлийн төлөвлөгөөг жендэрийн мэдрэмжтэй төсөвлөн батлуулсан. Хүйсээр ангилсан статистик мэдээний жагсаалт гаргасан. Цахим үйлчилгээний ажилтнуудыг жендэрийн ахисан түвшний сургалтуудад хамруулсан.
7.	Ойн нөхөрлөлийн гишүүдийн тэгш оролцоог хангах	Эмэгтэйчүүдийн оролцоог 50% болгож нэмэгдүүлэх	0	90%	Сумын ойн нөхөрлөлүүдэд сургалт хийж, нөхөрлөлийн гишүүдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах үзэсгэлэн худалдаанд оролцуулах боломжийг судалсан, 2 нөхөрлөлийг сонгон хамруулсан.
8.	Хүүхдэд ээлтэй орчин	ТАХ-ын ажиллах таатай орчин бүрдүүлнэ	2.9 сая	100%	Төрийн байгууллагад "Эх, хүүхдийн өрөө"-г тохижуулж, ашиглалтанд оруулсан



9.	Гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх зан үйлд нөлөөлөх	Эрэгтэй, эмэгтэй хүн гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх, сургалт сургалчилгаа хийж, мэдээлэл түгээх	0	94%	Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, гэмт хэргийн судалгааг сүүлийн 3 жилээр гаргасан. Гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр Канад улсын Засгийн газрын дэмжлэгтэй гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид эрх зүйн туслалцаа үзүүлэх нь сургалтад аймгийн төвөөс 6, Батсүмбэр, Заамар сумын Хууль эрх зүйн мэргэжилтнийг чадавхжуулах сургалтад хамруулж, гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр 8 сургагч багш бэлтгэсэн. Сүхбаатар, Хэнтий аймгийн гэр бүл хүүхэд залуучуудын газар, болон гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудтай туршлага солилцож ажилласан.
10.	Жирэмсэн эхчүүдийн ар гэрт, жирэмсний хяналтын чанарыг сайжруулах гэр үнэлгээг нэвтрүүлэх нь	Жирэмсний үеийн хүндрэлээс урьдчилан сэргийлэхэд гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэх	0	80%	Батсүмбэр сумын төвийн багийг сонгоод 23 жирэмсэн ээжийн мэдээллийг авсан. Эдгээр ээж, нехрийнх нь "Гэр үнэлгээ"-г хийнэ. Үүний дараа сургалт хийж, дараа нь үнэлгээг дахин хийж өөрчлөлт гарсан эсэхийг нягтална.
11.	Оюунлаг эмэгтэйчүүд	Зуунмод сумын багуудын гэртээ хүүхдээ хардаг ээжүүдэд номын сангийн үйлчилгээ хүргэж, хүртээмжийн зөрүүтэй байдлыг арилгах	0	100%	Оюунлаг эмэгтэйчүүд гэсэн 412 гишүүнтэй ФБ групп байгуулаад 7 хоногт цахимаар 2 ном оруулдаг. 4 удаагийн 40 номын танилцуулгаар цахим ном, сургамжит өгүүлүүд илүү их хандалттай байна. Зөврийн номын сангаар сард 15 ээжид 40 ном хүргэж өгсөн.
12.	Илүүдэл жингүй Угтаалын эмэгтэйчүүд	Сумын зорилтот бүлгийн болон хүүхдээ харж асрах, сургууль цэцэрлэгт хүргээд бусад цагт ажилгүй байгаа эмэгтэйчүүдийг фитнесэд хамруулж, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэдний нийгмийн эрүүл мэндийг сайжруулах	0	100%	Фитнест хамрагдсан иргэдийн судалгааг хийсэн. Судалгааны үндсэн дээр сонгогдсон 20 эмэгтэйт 7 хоногт 5 удаа фитнест хамруулж байна. Эдгээр эмэгтэйчүүдийг дасгалын ижил өнгийн хувцастай болгосон. Эмэгтэйчүүдийн хувцас солих өрөөг 200,0 төгрөгөөр шинээр тохижуулж ашиглалтад оруулсан. Эмэгтэйчүүдэд зориулсан төхөөрөмжийг нэмэгдүүлэхэд 450,0 мянган төгрөгийн хэрэгсэл авсан. Эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.

Дундговь аймагт хэрэгжсэн бичил төслүүд, багийн гишүүдийн мэдээлэл

№	Бичил төслийн нэр	Бичил төслийн багийн гишүүд, хүйс	Гишүүдийн ажлын газар албан тушаал
1	Төрийн албаны удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх	Г.Энхтайван	ЗДТГ-ын СТСХ-ийн дарга
		Х.Мөнхсаруул	ЗДТГ-ын ТЗУХ-ийн ахлах мэргэжилтэн
		Б.Алтантөгс	Эрүүл мэндийн газрын дарга
		Н.Сүхбаатар	ЗДТГ-ын СТСХ-ийн ахлах мэргэжилтэн
		Б.Батсайхан	Дундговь аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны улсын байцаагч
		Б.Жанчивдорж	Татварын хэлтсийн ахлах байцаагч
2	Байгаль хамгаалагч эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх	Б.Батхүү	БОАЖГ-ын ахлах мэргэжилтний үүрэг гүйцэтгэгч
		Ц.Загдсүрэн	ЭМГ-ын мэргэжилтэн
3	Гурвансайхан сумын ИТХ-ын зөвлөл, хороод дахь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх	Ц.Тогосмаа	Гурвансайхан сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга
		Б.Энхтуяа	Гурвансайхан сумын ЗДТГ-ын дарга
		З.Солонго	Цагаандэлгэр сумын ЗДТГ-ын дарга
		С.Болоржаргал	Сайхан-Овоо сумын ЗДТГ-ын дарга
4	Малчин өрхийн жендерийн хэвшмэл байдлыг өөрчлөх	Б.Өлзийхишиг	Луус сумын Засаг дарга
5	Тэгш оролцоотой гэр бүл - ЕБС	А.Ганцог	Дундговь аймгийн НДХ-ийн Тасгийн дарга
		Б.Адъяасүрэн	Дундговь аймгийн ОНӨГ-ын ХАА хариуцсан ахлах мэргэжилтэн
		Д.Мөнхбат	Хүмүүнлэг сургуулийн захирал
	Тэгш оролцоотой гэр бүл - Цэцэрлэг	О.Уранзаяа	Сайнцагаан сумын ЗДТГ-ын нийгмийн бодлогын мэргэжилтэн
		Б.Лхагвамандал	Эрдэнэдалай сумын Засаг дарга
		Л.Оюун	Сайнцагаан сумын 8-р цэцэрлэгийн эрхлэгч
6	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар орлогыг нь нэмэгдүүлэх	Т.Цэвэлмаа	Баянжаргалан сумын Засаг дарга
		Б.Мягмарсүрэн	БШУГ-ын Төсвийн мэргэжилтэн
		Э.Одончимэг	Аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ийн ахлах мэргэжилтэн
7	Мянгат малчдын зөвлөгөөнд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх	Б.Сэржмядаг	Адаацаг сумын Засаг даргын Орлогч
		Т.Саранчимэг	Мэргэжлийн хяналтын газрын ТЗЭУХ-ийн дарга



8	Уншигч эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх	А.Нансалмаа	Төв номын сангийн дарга
		Б.Оюунханд	Өлзийт сумын ЗДТГ-ын дарга
9	Малжуулах хөтөлбөрт эмэгтэй малчдын оролцоог нэмэгдүүлэх	Н.Дэлгэрмаа	ЗДТГ-ын НБХ-ийн ахлах мэргэжилтэн
		А.Мөнх-Эрдэнэ	БОАЖГ-ын мэргэжилтэн
		Т.Лхагвасүрэн	Дундговь аймгийн ХХҮГ-ын мэргэжилтэн

— - Эмэгтэй — - Эрэгтэй

Сүхбаатар аймагт хэрэгжсэн бичил төслүүд, багийн гишүүдийн мэдээлэл

№	Бичил төслийн нэр	Багийн гишүүд, хүйс	Гишүүдийн ажлын газар албан тушаал
1	Бүсгүйн гараа	Ц.Өлзийжаргал	Аймгийн залуучуудын холбооны тэргүүн
		М.Энэбиш	Аймгийн Насан туршийн боловсролын төвийн захирал
		Б.Болортуул	Баруун-Урт сумын ЗДТГ-ын хүний нөөцийн ажилтан
2	Хоршооны зээлд эмэгтэйчүүдийн оролцоог хангах нь	Р.Алтаннар	Аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн дарга
		Н.Идэрчулуун	Наран сумын Засаг даргын орлогч
		С.Болорчимэг	Аймгийн ХХААГ-ын мэргэжилтэн
3	Эмэгтэйчүүдийн ур чадварыг дээшлүүлж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх нь	М.Мөнхзул	Аймгийн ХХҮГ-ын хэлтсийн дарга
		Я.Отгон	Аймгийн ХХҮГ-ын хэлтсийн дарга
4	Аймгийн ЗДТГ-ын эмэгтэй албан хаагчдын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх нь	Б.Мөнхтуяа	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн ахлах мэргэжилтэн
		Б.Нарантуяа	Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
		О.Цэндсүрэн	Аймгийн ГБХЗХГ-ын мэргэжилтэн
5	Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт эмэгтэй байгаль хамгаалагчдын тоог нэмэгдүүлэх нь	Ц.Оюунгэрэл	Аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн
		Б.Нансалмаа	Дарьганга сумын ЗДТГ-ын санхүүгийн албаны дарга
		Д.Саранзаяа	Аймгийн ЭМГ-ын мэргэжилтэн
6	Соёл ба жендэр	Б.Золхүү	Аймгийн соёлын газрын ахлах мэргэжилтэн
		А.Бадмаараг	Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн ерөнхий нягтлан бодогч
7	Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь	Д.Мөнхнаран	Баруун-Урт сумын ИТХ-ын Төлөөлөгч
		О.Батсайхан	Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч
		Г.Батболд	Баруун-Урт сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга

8	Байгууллагын дотоод журам, ТАХ-дын нийгмийн баталгааны хөтөлбөрийг жендэрийн мэдрэмжтэй болгох нь	М.Оюунтөгс	Аймгийн ЗДТГ-ын хүний нөөц, бодлого хариуцсан мэргэжилтэн
		Я.Оюунзул	АЗДТГ-ын ТЗУХ-ийн ахлах мэргэжилтэн
		Б.Бямбадорж	АЗДТГ-ын НБХ-ийн ахлах мэргэжилтэн
		С.Баянмөнх	Сүхбаатар аймаг дахь төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
		С.Цогтбаатар	Уулбаян сумын ЗДТГ-ын дарга
9	Мэргэжлийн боловсрол эзэмшиж буй охидын тоог нэмэгдүүлэх нь	Л.Нарангарав	АЗДТГ-ын НБХ-ийн ахлах мэргэжилтэн
		Э.Хандсүмбэрэл	Аймгийн Боловсролын газрын мэргэжилтэн
10	Нийгмийн даатгалын хэлтсийн эмэгтэй ТАХ-ийн нийгмийн баталгааг нэмэгдүүлэх	Б.Бат- Амгалан	Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн тасгийн дарга
11	Жендэрийн мэдрэмжтэй спортыг дэмжих орон нутгийн бодлого боловсруулах нь	С.Ундрах	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн ахлах мэргэжилтэн
		Ж.Оюунтуяа	Асгат сумын ЗДТГ-ын санхүүгийн албаны дарга

— - Эмэгтэй

— - Эрэгтэй

Төв аймагт хэрэгжсэн бичил төслүүд, багийн гишүүдийн мэдээлэл

№	Бичил төслийн нэр	Багийн гишүүд, хүйс	Гишүүдийн ажлын газар албан тушаал
1	ХЭДС-аас олгож байгаа аж ахуй эрхлэгчдийг дэмжих санхүүгийн дэмжлэгийг жендэрийн мэдрэмжтэй хуваарилах	Ж.Цэрэнжаргал	Аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтэн
		Л.Пүрэвбаатар	Аймгийн ХХҮГ-ын Хөдөлмөрийн хэлтсийн дарга
		С.Батбаяр	Аймгийн Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
2	Албан томилолтын зардалд жендэрт суурилсан аудит хийх	Б.Саруул	Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн
		Т.Насанжаргал	Аймгийн МХГ-ын хэлтсийн дарга
3	Морин хуур хөгжмөөр хичээллэх охидын тоог нэмэгдүүлэх	Д.Амаржаргал	
		Б.Аминдаваа	Хүмүүн цогцолбор сургуулийн НУ-ны багш
		Б.Оюунтуяа	Лүн сумын ЕБС-ийн нийгмийн ажилтан



4	Эрдэнэ МСҮТ-ийн малчны ангид суралцах эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх нь	М.Ичинхорлоо	Заамар сумын Засаг даргын орлогч
		Ш.Отгонхүү	Эрдэнэ сумын МСҮТ-ийн захирал
5	Соёлын биет бус өвийн эмэгтэй өвлөн уламжлагчийг илрүүлж, нэмэгдүүлэх	Б.Тунгалаг	Аймгийн СУГ-ын дарга
		Б.Цэцэгбадам	Аймгийн ГБХЗХГ-ын ахлах мэргэжилтэн
6	Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд иргэдийн саналыг тусгахад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх	А.Туяажаргал	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн ахлах мэргэжилтэн
		Ц.Ууганбаатар	Аймгийн ЗДТГ-ын Хэвлэл мэдээллийн ахлах мэргэжилтэн
		Б.Мөнхбат	Аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ийн ахлах мэргэжилтэн
7	Ойн нөхөрлөлийн гишүүдийн тэгш оролцоог хангах	С.Эрдэнэцогт	БОАЖГ-ын ахлах мэргэжилтэн
		Н.Ундрахбилэг	Борнуур сумын Засаг дарга
8	Хүүхдэд ээлтэй орчин	Х.Түвшинжаргал	Аймгийн ХХААГ-ын албаны дарга
		Б.Одончимэг	ЗДТГ-ын СТСХ-ийн мэргэжилтэн
9	Гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх зан үйлд нөлөөлөх	Д.Сэдэд	Аймгийн ЗДТГ-ын хуулийн мэргэжилтэн
		С.Эрдэнэбилэг	Аймгийн Цагдаагийн газрын ахлах мөрдөн байцаагч
10	Жирэмсэн эхчүүдийн ар гэрт, жирэмсний хяналтын чанарыг сайжруулах гэр үнэлгээг нэвтрүүлэх нь	Т.Гүрбазар	Аймгийн ЭМГ-ын НЭМХ-ийн дарга
		Д.Дарьсүрэн	Аймгийн нэгдсэн эмнэлгийн урологийн эмч
11	Оюунлаг эмэгтэйчүүд	Өнөрцэцэг	Аймгийн нийтийн номын сангийн ном зүйч
		Мөнхцэцэг	Аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн дарга
12	Илүүдэл жингүй Угтаалын эмэгтэйчүүд	П.Оюунбилэг	Угтаалцайдам сумын ЗДТГ-ын дарга
		Д.Алтанхуяг	Аймгийн спортын газрын дарга
		Б.Оюунцэцэг	Аймгийн ЗДТГ, ТЗУХ-ийн ахлах мэргэжилтэн
		Н.Энхбат	Аймгийн бүртгэлийн газар дарга

— - Эмэгтэй

— - Эрэгтэй

Сүхбаатар аймаг: Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн манлайлал, оролцоог нэмэгдүүлэх бичил төсөл





- Холбогдох бусад төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллан тэдний дэмжлэгийг авч чадсан
- Өөрийн ажилтайгаа уялдуулсан
- Хүйсээр ангилсан тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн
- 100% амжилттай хэрэгжсэн төсөл

Төв аймаг: Эрдэнэ сумын МСҮТ-ийн сургуулийн малчны ангид эмэгтэй малчдыг хамруулах бичил төсөл


Төсөл хэрэгжсэнээр нийт 30 оюутан элсэн сурч байна. 16 нь эмэгтэй /53%/ 14 нь эрэгтэй байна.

- Сургуулийн тухайн ангийн танилцуулга шторкийг хийж мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлсэн.
- Сургалтын уян хатан бодлого нэвтрүүлэхээр төлөвлөсөн. 80% дадлага, 20% лекц
- Элсэлтийн журамд өөрчлөлт оруулсан
- Багийн гишүүдийн санаачилга чухал
- Өөрийн ажилтайгаа уялдуулсан
- Байгууллагын бусад гишүүдтэй хамтарч ажилласан
- Хүйсээр ангилсан тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн
- Тогтвортой байдал хангагдсан, бусад МСҮТ-дэд хэрэгжих боломжтой
- Тэг төсөвтэй
- 100% амжилттай хэрэгжсэн төсөл





 www.merit.mn
 fb.com/MERIT.mn
 support@merit.mn

 Монгол Улс, Улаанбаатар-15160,
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Худалдааны гудамж,
Нэйшнл Таймс Ньюс Тауэр,
3-р давхар